

НБД-ын 1993 оны 1282-р захирагчаар 212.
хувиар

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГАА, БНМАУ-ЫН ТЭЭВРИЙН ЯАМНЫ
ХАМТАРСАН ХУРЛЫН ТОГТООЛ

1987 оны 9 дүгээр
сарын 29-ны өдөр

Дугаар 284/326

Улаанбаатар
хот

Троллейбусны үйлчилгээний талаар
авах зарим арга хэмжээний тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1987 оны 267 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор нийслэл Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн тээврийн үйлчилгээнд 1987 оны 10 дугаар сарын 29 нээс эхлэн троллейбусны I ээлжийн эхний хэсгийг ашиглалтад оруулахтай холбогдуулан Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, БНМАУ-ын Тээврийн яамнаас ТОГТООХ нь:

1. Троллейбусны техник ашиглалтын дүрэм, троллейбусаар зорчих дүрэм, билет борлуулах, худалдах журам, троллейбусны буудлын нэр, маршрутыг 1, 2, 3, 4 дүгээр хавсралтуудаар баталж 1987 оны 10 дугаар сарын 29 нээс эхлэн жилийн хугацаагаар түр мөрдүүлсүгэй.

2. Хөдөлмөрчдийг троллейбусаар хөнгөн шуурхай, боловсон зөв үйлчлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаатай холбогдуулан энэхүү дүрэм, журмыг ажилтан, ажилчидаараа сайтар судлуулан чанд мөрдүүлэхийн хамт, биелэлтэнд байнга хяналт тавин ажиллахыг Троллейбусны комбинат /н.НЯМДАВАА/-д даалгасугай.

3. Троллейбусны үйлчилгээний онцлог, зорчигчдын эрх, үүргийг радио, телевиз, Улаанбаатарын мэдээ сониноор дамжуулан хөдөлмөрчдөд өргөн сурталчлах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол телевизын захиргаа /н.ХАРГАЛ/, Улаанбаатарын мэдээ сонин /н.МӨНХЖАРГАЛ/, Нийслэлийн нэвтрүүлгийн редакци /н.ЛХАГВАСҮРЭН/, Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны худалдааны хэлтэс /н.СҮХЭЭ /-т үүрэг болгосугай.

4. Троллейбусны тээвэрт ^{хүчингэс баригч}кондукторгүй үйлчилгээ нэвтрүүлэхтэй холбогдуулж автобус, троллейбусаар зорчих байнгын болон троллейбусны хяналтын билетийг нийслэлийн худалдаа, холбооны цэгүүд, авто тээврийн буудал, ахуйн үйлчилгээний газруудын касс, хотын банкны конторын тооцооны кассууд, зориулалтын кассуудаар дамжуулан худалдаалах арга хэмжээ авахыг Автобусны комбинат /н.ДАШЦЭРЭН/, Троллейбусны комбинат /н.НЯМДАВАА/, Хүнсний бараа худалдааны

2.

нэгдэл /н.ШАГДАР/, Цахилгаан шууданхолбооны газар /н. НАНСАЛЖАВ/, Ахуй үйлчилгээний удирдах газар /н.НАДМИД/, Хотын банкны контор /н.ЦЭРЭНДОРЖ/ -т үүрэг болгосугай.

5. Зорчигчдын сарын байнгын болон нэг удаа зорчих хяналтын билет борлуулсан орлогоос байгууллагад 3,0 хувийн шимтгэл олгож түүнээс худалдагч нарт борлуулалтын орлогоос 0,5 хувь хүртэл урамшуулал өгч байхыг холбогдох байгууллагын дарга, ерөнхий нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

6. Троллейбусны үйлчилгээний шугамын дагууд хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллахад шаардлагатай холбогдох замын тэмдэгүүдийг 10 дугаар сард багтаан байрлуулахыг Улсын авто техникийн хэргийг шалган байцаах газар /н.РЭНЦЭНДОРЖ/ -т даалгасугай.

7. Троллейбусны зам дээр ус, цас, мөс тогтох хальтиргаа гулгаа үүсэхээс урьдчилан сэргийлэх, гүн хонхорхой, нүх бий болох тохиолдолд шуурхай засварлаж байх үүрэг бүхий зам засвар, арчлалтын тусгай бригадыг зохих машин, механизм, бусад багаж хэрэгсэлтэйгээр /элс г. мэт материалтайгаар / байгуулж энэ оны 10 дугаар сараас эхлэн ажиллуулахыг Хот тохижуулах газар /н.БААТАР/ -т даалгасугай.

8. Троллейбусны зам, буудлын тохижилтыг ойролцоох дэвсгэрийн байгууллагуудад хуваарилж хариуцуулан ус, цас, мөсний цэвэрлэгээр байнга хийлгэж биелэлтэд хяналт тавьж ажиллахыг райодын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга нарт үүрэг болгосугай.

9. Троллейбусны хөдөлгөөнийг тасалдуулахгүйн тулд төлөвлөгөөт засварын ажлыг зөвхөн шөнийн цагаар богино хугацаанд хийж байхыг Цахилгаан шугам сүлжээний газар /н.ХАТАНБААТАР/ -т даалгасугай.

10. Троллейбусны контактын сүлжээ, кабелийн шугам болон бусад байгууламжийг гэмтээсэн, түүнээс шалтгаалан троллейбусны хөдөлгөөн зогсож хөдөлмөрчдийн үйлчилгээг саатуулсан албан байгууллага, хүмүүсээр учирсан хохирлыг төлүүлж байхыг Улсын автотехникийн хэргийг шалган байцаах газар /н.РЭНЦЭНДОРЖ/, Троллейбусны комбинат /н.НЯМДАВАА/ -д даалгасугай.

II. Троллейбусны кабелийн шугам сүлжээ нь төв замын дагууд болон элсад байрлаж байгаа цахилгааны хуваарилах байгууламжуудтай холбогдсон тул газар шорооны ажил хийхэд троллейбусны цахилгаан

3.

хангамжийн албанаас тусгай зөвшөөрөл авч, уг ажлыг өхлүүлж байхыг Барилга архитектур төлөвлөлтийн газар /н.ЖАДАМБА/, нийслэл хотын нийт үйлдвэр, аж ахуй, албан байгууллагуудын эрх баригч нарт даалгасугай.

12. Улаанбаатар хотын зорчигч тээврийн үйлчилгээг нэгтгэн зохион байгуулан автобус, троллейбус, таксийн өдөр дутмын үйл ажиллагаанд хяналт тавьж хөдөлгөөнийг зохицуулах зорилгоор төвлөрсөн диспетчерийн станц байгуулах асуудал боловсруулан холбогдох байгууллагад тавьж 1988 онд багтаан шийдвэрлүүлэхийг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд Худалдааны хэлтэс /н.СҮХЭЭ/, Тээврийн яамны тээврийн хэлтэс /н.ДҮРЭВДОРГ/-т даалгасугай.

13. Автобус, троллейбусаар зорчих нэгдсэн байнгын билетийн үнийг Үнэ стандартын улсын хороогоор энэ оны II дүгээр сард багтаан батлуулахыг Тээврийн яамны санхүү, тайлан бүртгэлийн хэлтэс /н.МОНХОР/, Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны санхүүгийн хэлтэс /н.ГОНГОР/-т даалгасугай.

14. Троллейбус тээврийн үйлчилгээнд ЗХУ-ын туршлагыг өргөнөөр нэвтрүүлж нийт ажилтан, ажилчид, жолооч, засварчдын мэргэжил мэдлэгийг байнга дээшлүүлэх системтэй ажил зохиож байхыг Тээврийн яамны боловсон хүчин, захиргааны газар /н.ЭНХБОЛД /, Троллейбусны комбинат /н.НЯМДАВАА/ -д даалгасугай.

15. Троллейбусны комбинат болон эцсийн цэгүүдэд жолооч, диспетчерийг хооллох цайны газрыг 10 дугаар сард багтаан гаргахыг Нийтийн хоолны удирдах газар /н.УРИАНХАЙ/, Троллейбусны комбинатад цехийн эмнэлэг, хүнсний мухлагийг энэ онд багтаан байгуулахыг Хүнсний бараа худалдааны нэгдэл /н. ШАГДАР/-д Хотын эрүүлийг хамгаалах газар /н.БЯМБАА/ -д үүрэг болгосугай.

16. Троллейбусны комбинат, бүх цахилгааны дэд станцуудыг хотын болон шууд утсан харилцаатай болгож арга хэмжээ авахыг Телефон радио ашиглалтын хороо /н.БАНЗРАГЧ /, Холбооны барилга

монтажийн газар /н.БААСАНЖАВ/, Траллейбусны комбинат /н.НЯМ-ДАВАА/-д үүрэг болгосугай.

17.Траллейбусны комбинатын ажилчид ахуйн үйлчилгээгээр тогтмол үйлчилж байх арга хэмжээ авахыг Ахуйн үйлчилгээний удирдах газар /н.НАДМИЦ/-т даалгасугай.

18.Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлж байнгын хяналт тавьж ажиллахыг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны тээвэр хариуцсан зохион байгуулагч /н.ДЭМЦ/, Тээврийн яамны тээврийн хэлтэс /н.ПҮРЭВДСРЖ/-т даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ДАРГА
[Signature]
С.МӨНХМАРТАЛ



ТЭЭВРИЙН ЯАМНЫ

[Signature]
Д.ЭНДСОНСҮРЭН

Улаанбаатар хотын АДУ-ны түүшт-
гэх Захиргаа, БНМАУ-ны Тэврийн
Яамны 1987 оны 284/32 тоот туша-
лын нэгцлэгээр хэвэрэж



ТРОЛЛЕЙБУСНЫ ТЕХНИК АШИГЛАЛТЫН

ДҮРЭМ

ооо

БАТЛАВ.УЛААНБААТАР УСТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИГЛАА,
ТЭЭВРИЙН ЯАМ.

1987 оны 10 дугаар
сарын 06 -ны өдөр № 284/326

ЗӨВШӨӨРӨВ.ТЭЭВЭР,ХСЛБОО,ХУДАЛДАА,
НИЙТИЙН АЖ АХУЙ,ҮЙЛЧИЛГЭЭ-
НИЙ АЖИЛЧЛЫН ҮЭ-ИЙН ТӨВ
ХСРСС.

1987 оны 9 дүгээр
сарын 25 -ны өдөр № 82.

ТҮЛШ ӨРЧИМ ХҮЧНИЙ ҮЭЛДВЭ-
РИЙН ЯАМ.

1987 оны 9 дүгээр
сарын 30 -ны өдөр. № 2/3569.

НИЙТИЙН АЖ АХУЛААС ХАМГАА-
ЛАХ ЯАМ.

1987 оны 10 дугаар
сарын 05 -ны өдөр № 23.

ТРОЛЛЕЙБУСНЫ ТЕХНИК АШИГЛАЛТЫН
Д Ү Р Э М

О Р Ш И Д

Энэ дүрмээр Троллейбусны техникийн ашиглалтад хамаарах ерөнхий заавар, барилга байгууламж, тоног төхөөрөмж, хөдлөх бүрэлдэхүүний техникийн үндсэн норм, хэмжээ болон хөдөлгөөнийг зохион байгуулах журмыг тогтоов.

Троллейбусны техник ашиглалтын дүрмийг хотын цахилгаан тээврийн бүх ажилчин болоу бусад холбогдох байгууллагын ажилтан, ажилчин нарийн судалж, чанд мөрдөх ёстой.

Троллейбусны техникийн ашиглалтын дүрэмд оёрчлөлт оруулах асуудлыг зөвхөн Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Зөхиргөө БНМАУ-ын Тээврийн яам, шийдвэрлэнэ.

Троллейбусны техникийн ашиглалтын талаар энэ дүрэмд тодорхой зааглаагүй асуудлууд болон холбогдох салбар, албадын ажлыг тодорхойлсон заавар, журмыг троллейбусны тээврийн комбинат боловсруулан баталж мөргүүлэх бөгөөд тэдгээр нь энэ дүрмийн шарцлагад зохицсон байвал зохино.

Троллейбусны техникийн ашиглалтын дүрмийн шарцлагыг нарийн чанд дагаж мөрдөх нь троллейбусны аюул осолгүй хэвийн ажиллах нөхцөлийг хангах үндэс мөн.

I. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:

I.1. Хотын цахилгаан тээврийн ажилчдын үүрэг хариуцлага

I.1.1. Хотын цахилгаан тээврийн ажиллагчдын үндсэн үүрэг бол хөдөлмөрчийг хөнгөн шуурхай, соёлч боловсон тээврийн үйлчилгээгээр ханган, троллейбусны хөдөлгөөний аюул ослоос урьдчилан сэргийлж ажиллахын зэрэгцээ хөдөлмөр болон материалын нөөцийг ариг гамтай зөв ашиглах явдал юм.

I.1.2. Хотын цахилгаан тээврийн ажилчин ажилтан нар нь хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлсөн ноцтой тохиоллын үед өөрөөсөө хамаарах урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг юуны өмнө хүний амь нас хохироохгүй байх, зам тээврийн осол гаргахгүйн тулд авах үүрэгтэй.

Троллейбусны үйлчилгээтэй хамбогцох ажилчин ажилтан нэг бүр ажил үүргийнхээ дагуу хөдөлгөөний аюулгүй байдлын талаар зохих хариуцлагыг хүлээнэ.

I.1.3. Ажилчин бүр өөрсдийн гүйцэтгэх ажилтай холбоотой хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны дүрэм зааврыг дагаж мөрдөх үүрэгтэй.

I.1.4. Хотын цахилгаан тээврийн ажилтан, ажилчин албан үүргээ гүйцэтгэж байхцаа формын хувцасыг заавал өмсч ядгах тэмдгийг зааврын дагуу хэрэглэх зорчигчид халамж анхаарал тавьж үйлчлэхийн зэрэгцээ тэдэнд троллейбусны ашиглалтын дүрмийн заалт бүрийг нарийн чанд биелүүлэхийг шаардана.

I.1.5. Хотын цахилгаан тээврийн ажилчин нь өмч хөрөнгийг нүдлэн хамгаалах үүрэгтэй.

I.1.6. Зорчигч тээвэрлэлтийн ажил хэрэглэгдэх барилга байгууламж, тоног төхөөрөмж, хөдлөх бүрэлдэхүүний бүрэн бүтэн ажиллагаатай байдлыг хангах зэвсэг үйлчилгээ, тохиргоог нормативын дагуу гүйцэтгэнэ.

1.1.7.Троллейбусны комбинат, хэлгэс, албацн удирдлага, холбогдох ажилтан ажилчин нь барилга байгууламж, тоног төхөөрөмж, хөдлөх бүрэлдэхүүний бүрэн бүтэн байдлыг албан ёсоор хариуцна.

1.1.8. Энэ дүрмийг хотын цахилгаан тээвэрт ажиллагчид мөрүүдж нэрэгжүүлэх үүргийг троллейбусны комбинат түүнд хэлтэс, албацн удирдлага, ажилтан бүр ажил үүргийн дагуу бүрэн хариуцна.

1.2. Хотын цахилгаан тээврийн ажилтан ажилчныг бэлтгэх, ажил элсүүлэх, мэдлэг мэргэжлийг шалгах:

1.2.1. Хотын цахилгаан тээвэрт ажиллах инженер-техникийн ажилтан, ажилчин, албан хаагчийг хууль тогтоомжийн дагуу ажил авна.Хөдөлмөрийн хүнд хортой нөхцөлч хамаарагдах ажил мэргэжил, үйлдвэрлэл, мөн 18 насанд хүрээгүй хүмүүсийг ажиллахыг хориглосон тухай МҮЭ-ийн Төв Зөвлөл, Хөдөлмөр нийгэм хангамжийн улсын хорооноос гаргасан журмыг мөрдөнө.

1.2.2.Троллейбусны хөдөлгөөнтэй холбоотой ажил үүрэг гүйцэтгэх, инженер-техникийн ажилтан, албан хаагчид, ажилчид болон хөдөлмөрийн ажилтай, хортой хүнд нөхцөлтэй ажил орж байгаа хүмүүс нь эмнэлгийн үзлэгт заавал хамаарагдсан байна.

1.2.3.Эмнэлгийн үзлэгээр орох ёстой ажилтан, ажилчин, албан хаагчдын ажил мэргэжлийн жагсаалт болон нийт ажиллагчдыг эмнэлгийн үзлэгт хамруулах үечилсэн хуваарийг холбогдох журмын дагуу Троллейбусны комбинат баталж мөрдөнө.

1.2.4. Цахилгаан тоног төхөөрөмж,цахилгааны татах пэд станцууд, контактын сүлжээ ба кабелийн холбох шугамууд, холбооны төхөөрөмж, депо, албацн үйлдвэрлэлийн бааз, замын анги, барилгын хэсэг, хөдлөх бүрэлдэхүүний засварын ажилчин, жолооч нар болон ажилгүйн техникийн мэргэжлийн группийг бэлтгэх мэргэжил олгох, тэдний мэдлэгийг шалгахыг Тулш эрчим хүчний үйлдвэрийн яамны баталсан цахилгаан төхөөрөмж ашиглах ажилгүйн

ажиллагааны дүрэм, цахилгаан төхөөрөмжийн техник ашиглалтын дүрмийг баримтлана.

1.2.5.Троллейбусны комбинатад ажиллах хүмүүс нь сургалтын тогтсон журмын дагуу троллейбусны техник ашиглалтын дүрэм, хотын цахилгаан тээврийн агуулгуйн ажиллагааны дүрэм, хөдөлмөрийн дотоод дүрэм болон ажил үүргийн зааврыг судалж шалгуулсан байх ёстой.

1.2.6.Троллейбусны техник ашиглалтын дүрмийн мэдлэгийг ажиллагчдаас хоёр жил тутамд нэгээс доошгүй удаа, хотын цахилгаан тээврийн агуулгуйн техникийн дүрмийн мэдлэгийн түвшинг зургаан сар тутамд нэгээс доошгүй удаа шалгах зааварчлага өгнө.

1.2.7.Троллейбусны техник ашиглалтын дүрмийн мэдлэгийн шалгалтыг ажиллагчдаас байгууллагын болон хэлтэс албагч нарга орлогч нэраар удирдуулсан комисс томилж үйлдвэрчний эвлэлийн байгууллагын төлөөлөгчийг байлцуулан явуулна.

1.2.8.Удирдын байлаас хамаарч ашиглалтын нэгдэм өөрчлөгдөх үед жолооч нарт өгөх ажлын зааварчлагыг троллейбусны комбинатын даргын шийдвэрээр тогтоосон хугацаанд өгнө.

1.2.9.Объект харшудсан хүмүүсийг бэлтгэх, мэдлэг мэргэжлийг нь шалгах, аттестатлах ажлыг түвш эрчим хүчний улсын хяналтын ерөнхий алба болон улсын барилгын хорооны техник эрчим хүчний хяналтын газар өөрсдийн баталсан норматив зааврын дагуу явуулна.

1.2.10. Өгсөн зааварчлага, мэдлэг мэргэжлийг шалгасан дүнг тусгай журналд бүртгэнэ.

1.3.Хотын цахилгаан тээврийн объектыг ашиглалтад оруулах дүрэм:

1.3.1.Барилга байгууламж, тоног төхөөрөмж, машин механизм, хөдлөх сүрэлдэхүүн ба тоноглол хэрэгслүүд нь батлагдсан зураг, техникийн нөхцөл, паспортын заасан тосол, техникийн ба ашиглалтын үндсэн үзүүлэлтүүдтэй тохирч байх ёстой.

1.3.2.Шинээр барилгдсан болон шинэчлэлт хийсэн объектыг ашиглалтад оруулахны өмнө заасан туршилтын хугацаанд ажиллуу-

луулах хэрэгтэй.

1.3.3. Урьдчилан ажиллуулж, талгах гэл зорилго нь:

-Хөдлөх бүрэлдэхүүн ба тоног төхөөрөмж барилга байгууламжийн бэлэн байдлын зэргийг шалгах,

-Дутуу хийгдсэн ба мөрсөн гэмтлүүнийг эрхлэх

-Тоног төхөөрөмжүүдэд чяагдалгаа хийж тохируулах, троллейбусыг зорчигчгүйгээр шугаманд ажилдуулж зүгшрүүлэлт хийх

-Объектыг бүхэлд нь ашиглалтад хүлээлгэн өгөхөц шаардагдах техникийн бүх баримт бичиг, зурвэг төсөд, бусад холбогдох материалыг бэлэн болгох

-Сэдвэг, бэлгэ, ашиглалтын бусад материалыг бүрэлдүүлэн бэлтгэх,

-Засвар үйлчилгээний технологийн схем, ашиглалтын үеийн график ба ажиллагчдын ажил үүргийн зааврыг бэлэн болгох

-Ажиллагчдыг бэлтгэх, тэднийг объект ажиллуулах заавар журмын мэдлэгийг нэлгэх

-Техник ашиглалтын тооцоо, тоо бүртгэлдн журмыг тогтооно.

1.3.4.Шинээр байгуулагдсан ба өргөтгөл, шинэчлэлт хийсэн хотын цахилгаан тээврийн объектыг нээн байгууллагаас томилсон улсын комисс хүлээн авна.

1.3.5.Үйлдвэр, албан газар буюу захиалагч байгуулагч нардын тушаалаар томилогдсон ажлын комисс нь улсын комиссыг хүлээн авахаас өмнө объектыг хүлээн авсан байх хэрэгтэй.

1.3.6. Улсын ба ажлын комиссын бүрэлдэхүүн, тэдний ажиллах параалел, журмыг СНП "барьж нуусгасан үйлдвэр албан газар, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах" барилгын ном журмээр тогтооно.

1.3.7. Барьж нуусгасан үйлдвэр барилга байгууламж, контактны сүлжээ, зам, цахилгааны татэх нэл станц болон бууруулах нэл станцуудыг ашиглалтад хүлээлгэн өгөх тухай барил-

гын норм түрэмд заагтсан баримт бичгийг Ерөнхий гүйцэтгэгч /Барилга угсралтын байгууллага/ ажлын комисст шалгуулахаар бэлтгэсэн байна. Үүнээс гадна:

Зураг төсөлд оруулсан өөрчлөлт, түүний шалтгааныг тайлбарласан журнал, эд хөрөнгө, багаж, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалт бэх шаварлагатай.

1.3.8. Объектыг хүлээн авах улсын ба ажлын комисс нь зохих шаардлагын дагуу актыг бүрдүүлж, актанд комиссын гишүүн бүрээр гарын үсэг зуруулсан байна.

1.3.9. Объектыг хүлээн авах улсын комиссын актыг улсын комиссыг томилсон байгууллагаар батлагдсаны дараа троллейбусыг зорчигч тээвэрлүүдэхээр үйлчилгээнд гаргаж болно.

2. Хөдлөх бүрэлдэхүүн, засвар эмшлэлтийн цено;

2.1. Хөдлөх бүрэлдэхүүний төрөл ба зориулалт

2.1.1. Хөдлөх бүрэлдэхүүнийг зорчигч тээврийн /хүн эмг үйлчлэх/ тусгай зориулалтын /сургуулийн, ачааны гэх мэт/ гэж ангилна.

2.2. Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтанд оруулах, цэнснээс хасах журам

2.2.1. Хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээн авч шугаманд ажиллуулахын өмнө бүх төхөөрөмжид үзлэг тохируулга хийж 50 км-ээс доошгүй замд явуулах туршиж шаардлагатай.

2.2.2. Хөдлөх бүрэлдэхүүн бүрийн гараашийн дугаарыг кузовын урд, хойт, хажуу талд болон зорчигчийн зааланд бичнэ.

2.2.3. Эдэлгээний хугацаа, гүйцэтгэлийн норм гүйцсэн хөдлөх бүрэлдэхүүнийг Тээврийн яамны шийдвэрээр цэнснээс хасна.

2.3. Хөдлөх бүрэлдэхүүний засвар, техникийн үйлчилгээ:

2.3.1. Засвар, техникийн үйлчилгээний зорилго нь хөдлөх бүрэлдэхүүний техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, гадна өнгө үзэмжийг сайн байлгах болон кузов, агрегат, эд ангийн эцэглээний хугацааг уртасгахад оршино.

2.3.2. Хөдлөх бүрэлдэхүүний засвар, техникийн үйлчилгээг Тээврийн яамнаас баталсан засвар, техникийн үйлчилгээний дүрэм, техникийн нөхцөлийг баримталж гүйцэтгэнэ.

2.3.3. Үйлдвэрлэгч-заводын зөвшөөрөлгүйгээр хөдлөх бүрэлдэхүүний хийц, бүтцийг өөрчлөхийг хориглоно.

2.3.4. Ашиглагдаж байгаа троллейбусны хөдөлгөөний хувийн эсэргүүцэл нь Тээврийн яамнаас баталсан заавраар тогтоосон норм хэмжээнд байх ёстой. Ашиглалтын үед троллейбусны хөдөлгөөний хувийн эсэргүүцлийг техникийн үйлчилгээгээр хэмжилт хийж тооцооны цэвтэрт тэмцэглэж байх шаардлагатай.

2.3.5. Шугаманд ажиллаж байгаа троллейбусанд эмнэлгийн арнугалыг Эрүүдийг хамгаалах яамнаас баталсан графикайн дагуу хотын арлуун цэвэр халдвар судлалын станц гүйцэтгэнэ.

2.3.6. Шугаманд гараагүй троллейбусыг депоц тавихдаа:
Хөдөлгүүрийн эргэлт солигчийг завсарын байрлалд тавьж хөдөлгүүрийн эргэлт солигчийн барилд буюу хэрэв зохиомжоороо хүчний автоматын түлхүүртэй бол түүнийг авна.

- Троллейбусны гар тоормозыг татсан байна.
- Үндсэн болон туслах цахилгааны хэлхээг салгана.
- Цонх салхивчийг хаана.
- Гүйдэл хүлээх ачаагчийг контактын сулжээнээс салгах найдвартай бөхлөнэ.
- Зорчигчийн заалны болон жолоочийн кабина халдгыг хаана.
- Троллейбусыг тавихдаа өнхөрөхөөс хамгаалах дугуйнд нь ивүүр тавина.

-Хийн системийн тундасыг авна.

2.4.Троллейбусны засвар ашигналтын депо :

2.4.1. Депо нь хөдлөх бүрэлдэхүүнийг засвар, техникийн үйлчилгээ хийх, хөдлөх бүрэлдэхүүнийг хадгалах зориулалттай.

2.4.2.Засварын цех, тасгууд болон үйлдвэрлэлийн үндсэн ба туслах байрны барилгын хэмжээ, зохион байгуулалт, тэдгээрийн гэрэлтүүдэг, хадаалт, сэлхивч, усан ба цахилгаан хангамж, бохир усны шугам, мөн хөдлөх бүрэлдэхүүнийг засвар, үйлчилгээний зориулалттай бусад байгууламж, суваг, постын тоо, хийцүүд хөдөлмөр хамгаалалтын системийн стандарт /ССЕГ/, Барилгын норм ба дүрэм /СНХТ/, тухайн байгууллагын ажлын программын шаардлагыг хангасан байна.

Троллейбусны комбинатын барилга байгууламжийн архитектур, байрны цогцон тавилга, орчин тохижилт техникийн гоо үзэмж, хот байгууламжийн шаардлагыг хангасан байна.Троллейбусны комбинатын барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэлт хийх зураг төслийг зургийн байгууллага тогтсон журмын дагуу боловсруулна.

2.4.3. Хөдлөх бүрэлдэхүүнийг засвар, үйлчилгээг явуулах байгууллага /троллейбусны комбинатад мөрдөгдөж байгаа хуваарийн дагуу/ технологийн тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

2.4.4.Троллейбусны комбинатын талбайг хашаагаар хамгаалсан, гэрэлтүүлсэн, зүдэгжүүлсэн тохижуулсан байх шаардлагатай.

2.4.5.Троллейбусны комбинатын барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг зохих журмын дагуу хамгаалж байна.

2.4.6.Троллейбусны комбинат инженер-техникийн ажилтан, албан хаагчдаас гадна аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалдыг харуцсан техникийн ажилтаныг томилсон байна.

2.4.7.Троллейбусны комбинатын цех бүрийн ажлын онцлогтой холбогдсон хөдөлмөрийн цогцон журам ажлын нөхцөл, гадны аюулгүй болон аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн ариун цэврийн дүрэм, заавар, нүүдгэн шилжүүлэх схемийг харгалзах газар байрлуулсан байна.

2.5. Хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд тавих шаардлага:

2.5.1. Шугаманд гаргаж байгаа троллейбусны техникийн байдал нь троллейбусны засвар, техникийн үйлчилгээний гурэм болон энэ пүрхийн шаардлагыг хангасан байна.

2.5.2. Троллейбусны тоормозны системийн эцэс нь тогтоосон горимыг баримтлан ажиллах үеэ замд аль ч хэсэгт хөдөлгөөний аюулгүй байдалд найдвартай хангаж байх ёстой. Асфальтон хучилттай хуурай, тэгш зам дээр 30 км/цагийн хурдас эхэлж огцом тормозлох үеэ /цахилгаан, механик тормоз зэрэг ажиллахад/ хоосон троллейбусны тоормозны зам II э-ээс хэргэхгүй байх ёстой.

2.5.3. Троллейбусны жолоочийн суудалд хэргэж нь хөдөлмөр хамгаллын системийн улсын стандарттай тохирсон байна. Тэдгээртээ авч байгаа троллейбусны жолоочийн суудалд үйлдвэрлэсэн зөвхөн зурагтай тохирч байх ёстой.

2.5.4. Шугамд гарахад бэлэн болсон троллейбусанд дараах зүйлүүд байх ёстой. Үүнд:

-Нүүрс хүчлийн буюу нунтаг гад унтраагч, эсвэл хуурай элстэй хайрцаг

-Дээврийн салбар шат /Троллейбусанд байхаар тооцсон бол/

-Урд, хойт талын маршрутын тэмдэг ба хажуугийн хаяг

-Троллейбусыг зорчих цэрэм,

-Чанга яригч хэрэгсэл

-Троллейбус өнхөрөхөөс хамгаалсан ивүүр

-Зогсолтын үеийн аюулгүй ажиллагааны тэмдэг

Жолооч дараахи зүйлийг авч явах ёстой. Үүнд:

-Хөдөлгөөний эргэлт солигчийн бэрхүү /троллейбусанд байхаар тооцсон бол/

-Шаардагтах багажууд

-Хайлаг гад хамгаалагч, гүйцэл хүлээн авагчийн толгойн нүүрсэн дамжуулагч,

-Хуруутай хөндийрүүлэгч бээлий

-Хөндийрүүлэгч ба ерийн материалдаас хослуулж хийсэн бээлий

-Троллейбус жолоодох эрхийн үнэмлэх

-Замын хуудас

-Молоочийн цэвтэр

Хөдөлгөөний график хуваарь

-Ээлж хооронд троллейбус хүлээлцэх цэвтэр.

-Удбар шар энгийн хантааз

2.6. Шугам цахь хөдлөх бүрэлдэхүүний техникийн ашиглалт:

2.6.1. Хөдлөх бүрэлдэхүүний техникийн бүрэн бүтэн байдал, иж бүрлэлт болон гадраад өнгө үзэмж, мөн троллейбус хүлээлцэх цэвтрийн бичилтийг шугаманд гарахын өмнө жолооч завал шалгана.

2.6.2. Дор цурьдсан гэмтлүүдээс аль нэг нь байгаа тохиолдолд троллейбусыг шугаманд гаргах ажиллуулахыг хориглоно.

2.6.3. Тоормозны систем

-Тоормозны системийн эд ангиудын хийцийг өөрчлөх

-Хөл тоормозны цөрөөн цээр нэг удаа гишгэхэд гүйцэт хягд тоормослон зогсохгүй шарвах буюу тоормоз зуурах

-Аль нэг төрлийн тоормоз нь ажиллахгүй байхад

-Цахилгаан хийн тоормоз нь троллейбусыг тоормозны тогтоосон зайн зогсоож чадахгүй байх

-Гар тоормоз нь зөвшөөрөгдөх хамгийн их налуу газар троллейбусыг хөдөлгөхгүй барьж чадахгүй бол /8, 2,14-р зүйлийг үзэх/

-Гар тоормозны хөшүүрэг түгжигдэхгүй байхад

-Хийн системийн манометр ажиллахгүй байх компрессор шаардлагатай даралтыг хангаж чадахгүй байх

-Тоормозны гишгүүр гацаж байгаа тохиолдолд

2.6.4. Жолооны ухирлага

-Хөдөлгөч пугуй шулуун пугамын хөдөлгөөнд тавигдсан үед жолооны хүрлийн сул явалт 25 градусаас хэтэрч байхад

-Жолооны хүрлийн эргэлт хүндтэлтэй байхад

-Жолооны ухирлагын хүчлүүр гэмтэлтэй байхад

-Жолооны механизмын бэхэлгээ сударсан буюу гэмтсэн тохиолдолд

10

- Жолооны механизм гэрээс тос нэвчлж бэвээл

2.6.5. Дугуй ба резин дугуй

-Дугуйны бөхөлдгээний гайж, шилъкний нэг нь суларсан хугарсан байх

-Дугуй бусад эц ангитай хавирч байх

-Урд дугуйнд хоёрдугаар зэргийн сэргээ засварласан резин дугуй тавьсан тохиолдол:

Дугуйны хээний гүн 2 мм-ээс бага, хээ нь урагдсан буюу хуурсан тохиолдолд,

-Дугуйны хийн даралт тогтоосон хэмжээнд тохирохгүй байх

Дугуйн обуданд нуух түгжээ нь муу суух буюу гэмтэлтэй байх

2.6.6. Карданы дамжуулга:

Хөндлөгүүрийн болон редукторын гол цээх фланцын суулт, бөхөлдгээ нь суларсан байх

-Карданы нугасны тэнхлэгийн эвц, шлицын холбоосны рашпусын дагуух эвц шөвшөөрөгдсөн нормоос хэтэрсэн байх

2.6.7. Ерөнхий ба захын дамжуулга:

-Картер ба тагны бөхөлдгээний шилъкний нэг нь суларсан, хугарсан байх

-Их хэмжээгээр тос нэвчлж байх

-Дамжуулагчийн галны нуу чимээ гарсан байх

2.6.8. Хийн систем:

-Хийн системийн ажлын даралт хүртэл хий хураах хугацаа зөвшөөрөгдсөн нормоос их байх үед:

-Даралт тохируулагч нь ЗИУ- 682 маркийн троллейбусны хийн даралтыг 0,65- 0,8 МПа/ 6,5- 8 кгс/ см²/ хэмжээнд барьж чадахгүй байх/

-Хийн тоормозоор тоормозлогдсон троллейбусны хийн системээс гарч байгаа хийн алдагдал 30 минутанд 0,15 МПа/ 1,5 кгс/см²/ тоормозлогдоогүй троллейбусанд 0,05 МПа/ 0,5 кгс/см²/ - аас хэтэрч байх

II

- Хамгаалах класан дацгүй байх
- Тоормозны кран ажиллахгүй байх
- Манометр ажилдахгүй байх

2.6.9.Троллейбусны гүйдэл хүлээн авах төхөөрөмж контактын сүлжээний утаснаас гүйдэл хүлээн авагчийн толгой мултэрч байх

-Гүйдэл хүлээн авагчийн тулгуур хэвдсэн, ан цэв лэрсэн, муруйсан байх

-Гүйдэл хүлээн авагчийн шилжих хөдөлгөөн нь гадна байх

-Гүйдэл хүлээн авагчийн толгой гэмтэх,

-Гүйдэл хүлээн авагчийн толгойг тулгуураас мултрахад унхаас хамгаалах хэрэгсэл /гиэм хэрэгсэл байвал/ гэмтэх

-Гүйдэл хүлээн авагчийн тулгуурын өргөгчөх, буухыг хязгвардсан төхөөрөмжийн тохиргоо алдагдэх, гэмтэлтэй байх

-Гүйдэл хүлээн авагчийн тулгуурын гатах цуршийн тохиргоо алдагдах

-Контактын сүлжээний утасны бэхлэгээний өнцөг 5,5 м байхад ЗИУ- 682 маркийн троллейбус гүйдэл хүлээн авагчийн дархах даралт 120- 140 н/12-14 кгс/хэмжээнээс зөв байх

-Гүйдэл хүлээн авагчийн олс, бэлт, тусгаарлагч гэмтэлтэй байх

-Троллейбусны дээврийн цахилгаан тусгаарлах материалаар хийсэн хуудас /доронд/ байхгүй буюу гэмтэх.

2.6.10.Цахилгаан төхөөрөмж:

Үндсэн хөдөлгүүр, туслах чанарын цахилгаан хөдөлгүүр, хурд тохируулах машинууд, асаалт тохируулгын ба хамгаалах аппаратууд, цахилгааны туслах хэлхээ, аккумуляторын эхлэдэгээ алдагдах:

-Цахилгаан гүйдлийн алдагдал Зм А-аас хэтэрч байх

-Хяалга, шил эрчигчийн нэмжүүлгүүд ажилгүй болох

-Гэрлэн ба нуут похиолод ажиллахгүй байх

-Зориулалтын бус гад хамгаалагч тавьсан байх

-Хянах, хэмжих багажнууд ажилдахгүй байх

2.6.11. Гадна гэрлийн хэрэгсэл

-Гэрэл, дохионы системийн унтраалга, шилжүүлэгч гэмтсэн байх

-Том гэрэл асахгүй бусу тохирдоггүй байх

-Эргэх, зогсох эвэрх тохиололт гэрэл ажиллахгүй байх

Тайлбар: Шугаманг ажиллаж байхад эвэ нэг эвэрх болон том гэрэл асахгүй бол троллейбусны эгүү галыг гэрэлтэй байлгах ёстой.

2.6.12. Кузов :

-Шил арчигч, цан: үлээгч ажиллахгүй байх

-Хавдганы гишгүүр, баргууны бэхэлгээ сулрах

-Орох тасах хаалганы гишгүүр, баргууны цахилгаан тусгаарлагч бүрхүүл гэмтэх, урвалж

-Хээлгэ, цалны талны бөхөлгөө сулрах

-Жолсоочийн бүхрээгний шил, толгой хэрэглэх тусгай хэлбэр өөрчлөгдөх, муу үзэглэхээр гэмтэл гаргах

-Чанга явигч хэрэгсэл ажиллахгүй болгох

-Дэвэрээс ус гоожиж нэвчиж

-Троллейбусны чэрэх хэрэгсэл ажиллахгүй байх

2.6.13. Устай, ноён, цэстэй эвэ нэг троллейбусны хөдөлгөөн 5 км/цагийн хурднаас хэтрэхгүй байх ба усны түвшин, ноёнтой нэвсэн зузаан нь замны хучилтаас дээш 150 мм- эвэ бүүтэй замд троллейбусны хөдөлгөөнийг хормогдоно.

2.7. Хөдлөх бүрэлдэхүүнийг шугаманд ажиллах үед хийх техникийн үйлчилгээ

2.7.1. Хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд хяналт тавих, гарч болох гэмтлийг эргийгх зорилгоор шугаманд зэсварын цэг байгуулах, түүнд троллейбусны тэнэг төхөөрөмжинд сүх төрлийн засварын аалыг ажилгүй ажиллагаанд шилжүүлж дагуу гүйцэтгэх чатвартай засварчныг ажиллуулах.

2.7.2. Шугамны засварын цэгт ажиллах засварчид нь шугамд ажиллах байгаа хүмүүс болон жолоочийн захиалгын цагуу гарсан гэмтлийг эргийгханаас гадна троллейбусанд гэмтэл тохмолдохоос урьдчилан сэргийлэх үзлэг хийж байх үүрэгтэй.

2.7.3. Троллейбусны засварын эвнэ гүйцэтгэсэн жолооч, зэсварчин нь троллейбусны засвар, техникийн үйлчилгээний бүртгэлийн гэгтэрт засвар хийсэн тухай тэмдэглэл хийж гарин үсгээ зурсан байна.

2.8. Техникийн түргэн тусламж:

2.8.1. Шугамд ажиллаж байгаа троллейбусны гэмтэл, зам тээврийн ослыг богино хугацаанд арилгах зорилгоор техникийн түргэн тусламжийг зохион байгуулна.

2.8.2. Техникийн түргэн тусламжийн ажлыг тусгай зөлжээр ажиллагааг бригад, эсвэл депогийн засварын бригад гүйцэтгэнэ.

2.8.3. Техникийн түргэн тусламжийн бригад тээврийн хэрэгсэлээр хангагдсан байх ба түргэн хугацаанд ажилд гарахад байнга бэлэн байна.

2.8.4. Техникийн түргэн тусламжийн бригад нь ахлах /төвийн/ диспетчерийн шууд удирдлагаар ажиллана.

2.8.5. Техникийн түргэн тусламжийн автомашин нь өргөх механизм шаарцлагатай багаж сэлбэг, эвулгүй ажиллагааны хамгаалах хэрэгслүүд, похио, замын хаалтаар хангагдсан байна. Байнга хэрэглэгдэж байх багаж, материал гэх мэт зүйлийн жагсаалт, тэлгээрийг ээлж солигдох үед хүлээлцэж байх журмыг цено, эл ба бүрт гаргасан байна.

2.8.6. Техникийн түргэн тусламжийн автомашин нь хоёр талын богино долгионы радио холбооны төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

2.8.7. Техникийн түргэн тусламжийн бригад эвулгүй ажиллагааны дүрмийг хатуу мөрдөж ажиллана.

2.8.8. Техникийн түргэн тусламжийн бригадыг бригадын дарга /мастер/ удирдана. Хэд хэдэн бригад ажиллах тохиолдолд гэмтэл гарсан газар эхэлж ирсэн бригадын дарга /мастер/ ажлыг удирдах ба эсвэл захиргааны техникийн ажилтнаас тэр ажлыг удирдахаар томилогдон ирсэн ажилтан удирдана.

2.8.9. Троллейбусны комбинатын бүх ажилтнууд хөдөлгөөний саатлыг түргэн хугацаанд арилгахын тулд техникийн түргэн тусламжийн бригадын бүх талын дэмжлэг тусалцааг үзүүлэх үүрэгтэй.

2.8.10. Гэмтэл гарсан троллейбусыг ахлах /төвийн/ диспетчерийн зөвшөөрлөөр цепоруу явуулах ба уг троллейбусанд тогтоосон журмын дагуу засвар хийхээр өгсөн зөвшөөрөл, депод оруулж

байгаа шалтгаан, хөдөлгөөний аюулгүй байцлыг урьнаас хангах арга хэмжээг троллейбусны засвар, техникийн үйлчилгээний бүртгэлийн лэвтэр, замын хуудсанд бичсэн байна.

2.8.11. Депод оруулж байгаа троллейбусыг тусгай зааврын цагуу педагогийн ажилтан хүлээж авна.

2.9. Хөдлөх бүрэлдэхүүнийг намар өвлийн улиралд шугамд ашиглах:

2.9.1. Тээврийн яамнаас баталсан зааврын цагуу тогтоосон хугацаанд улирлын бэлтгэл ажлыг төлөвлөгөөтэйгээр хийж цэцэ, хөдлөх бүрэлдэхүүнийг өвөл ашиглахад бэлэн болгоно.

2.9.2. Бүх жолооч нар өөрсдийн хармуцсан троллей бусаа өвлийн улиралд бэлтгэхэд оролцоно.

2.9.3. Троллейбусны комбинат троллейбусны жолоочийн ажил үүргийн үндсэн зааврыг баримтлан өвлийн улирлын тоцорхой нөхцөлд хөдлөх бүрэлдэхүүнийг ажиллуулах жолоочийн ажил үүргийн зааврыг боловсруулан баталж мөрдүүднэ.

2.10. Хөдлөх бүрэлдэхүүний засвар, техникийн үйлчилгээний тооцоо бүртгэл:

2.10.1. Тооцоо бүртгэл нь дараахь боломжийг хангасан байна. Үүнд:

-Хөдлөх бүрэлдэхүүнд урсгал засварын үед хийсэн ажлын хэмжээ, хугацаа, түүнд ямар гэмтэл байгааг шуурхай мэдээлдээр байнга авч байх:

-Хөдлөх бүрэлдэхүүн, агрегатын засвар, техникийн үйлчилгээний талаар троллейбусны засвар үйлчилгээний газрын ажилд шинжилгээ хийгдэнэ.

" -Хөдөлгөөний аюулгүй байцлыг хангахад гол үүрэг гүйцэтгэдэг агрегат, зангилгааны засвар, техникийн үйлчилгээ хийсэн ажилчныг мэдэх боломжтойгоор ажлыг зохин байгуулна.

2.10.2. Троллейбусны комбинат депод хөдлөх бүрэлдэхүүний засвар, техникийн үйлчилгээний ажилчны ажил үүргийн заавар байх ба түүнийг биелэлтэнд хяналт тавьж ажиглана.

2.10.3. Троллейбус бүрт троллейбусны засвар, техникийн үйлчилгээний бүртгэлийн цэвтэр, паспорт мөн троллейбус, зүтгэгч хөдөлгүүр, мотор-компрессор, туслах хөдөлгүүр, хоёрт тэнхлэг болон пугуйнц засвар хийсэн тухай цагалдах хууцас хөтлөх ёстой.

2.10.4. Дугаарлагдаж хийгдсэн засвар, техникийн үйлчилгээний бүртгэлийн цэвтэрт троллейбусны ашиглалтын үеи гарсан бүх гэмтлийг жолооч тэмдэглэх ба техникийн үйлчилгээнд хийгдсэн аялууд болон троллейбус шугаманд гарахад болон байгаа тухай бичигтэнэ. Троллейбусны засвар, техникийн үйлчилгээний бүртгэлийн цэвтрийг сард нэгээс доошгүй удаа депогийн царга, ахлах инженер нар шалгаж тэмдэглэл хийж байна.

Троллейбусны засвар, техникийн үйлчилгээний бүртгэлийн цэвтрийг сүүлчийн удаа тэмдэглэл хийсэн өдрөөс хоёр нэг жилийн хугацаанд хөтгөлнө.

2.10.5. Троллейбусны депод цэрвэх зүйлүүд байх шаардлагатай.

-Урсгал засвар, техникийн үйлчилгээний бүртгэл тооцооны цэвтэр.

-Троллейбусны засвар, гэмтлийн талаар жолоочоос мэдүүдсэн захиалгын цэвтэр

-Троллейбусны ашиглалтын үе цэвх хувийн эсэргүүцлийн хэмжилтийн дунг тэмдэглэх цэвтэр

-Дугуйн хийн цэралтын хэмжилтийн журнал

-Депогийн пугуйн засвар, угсралтын цехүүдэд пугуй олгосон бүртгэлийн журнал

-Цахилгаан гүйцлэлийн олшгчдын хэмжилтийн дун бүртгэх журнал

2.10.6. Хөглөх бүрэлдэхүүний засварын ажлын тооцоо бүртгэл нь троллейбусны депод хөтгөлнөнө. Уг тооцоо бүртгэлд засвар хоорондын гүйлт, техникийн байдал, засварын ажил бүсэд техникийн мэдээ, тайдланг хөглөх бүрэлдэхүүнээр болон зарим агрегатвар гаргах тусгах бөгөөд мөн троллейбусны гүйлтийг

замын хуудсанд тэмцэглэснээр нь бүртгэнэ.

3.1. Тогтмол гүйцлийн цахилгааны татах пэд станц

3.1. Ерөнхий шаардлага

3.1.1. Энэ нүрэм нь троллейбусны цахилгааны татах пэд станцыг ажиллуулахад мөрдөнө.

3.1.2. Цахилгаан татах пэд станц нь тэжээлийн шугамуудаар дамжуулан троллейбусыг цахилгаанээр хангана.

3.1.3. Цахилгаан- татах пэд станц нь дараах бүрмүүлийн шаардлагыг бүрэн хангасан байна. Үүнэ:

- Цахилгаан төхөөрөмжийн байгууламжийн нүрэм
- Хэрэглэгчийн цахилгаан тоногловын үеэ мөрдөх агуулгүй ажиллагааны нүрэм
- Аж үйлдвэрийн барилгын зураг төслийн норм, нүрэм /СНИП/
- Галын агуулгүй ажиллагааны нүрэм
- Үйлдвэрийн эрүүд эхуйн нүрэм
- Троллейбусны техник шингээлтэн нүрэм

3.1.4. Хотын цахилгаан тээвэр нь эрчим хүч хэрэглэгчдийн нэгдүгээр зэрэгт хамарагдана. Хувьсах гүйцлийн цахилгаан эрчим хүчээр тэжээгдэж байгаа татах пэд станцын тэжээлийн схем нь троллейбусны цахилгаан хангамжийн сүлжээний системтэй тохирч байх ёстой.

Цахилгаан татах пэд станцын тэжээлийн төвлөрсөн системээс хангахтаа хоёр түсгүүрээс 2-оос доошгүй оруулгаар гүйцэтгэнэ. /Нэг тэжээлийн төв буюу хувааривах цэгийн янз бүрийн сөмдөөс/

Цахилгаан татах пэд станцын тэжээлийн шугамын нэг оролтыг цахилгаан хангамжийн 6 төвлөрсөн байгууламжаас, нөгөөг зөргөлдөө татах пэд станцаас авсан байдлаар цахилгаан хангамжийн төвлөрсөн байгууламжаас авч байгаа оролтын талыг татах хоёр пэд станцын эхлэн чандыг хангахад тооцох ёстой.

Татах пэд станцыг тэжээлийн шугамын нэг оролтоор тэмдэг болно. Гэхдээ оролтын тэжээл төсөрсөн үед троллейбусны хөдөлгөөнийг саятуулахгүй байх зорилгоор тэжээлийн шугамын өөр пэд станцаар шуурхай холбох бүрэн боломжтой байвал зохно. /Төвлөрөөгүй сис-

3.1.5. Тогтмол гүйцлийн шинэ цэх хүчдэл ажлын ачаалалтай үед 600-700 В, ачаалалгүй бол 780 В хүртэл өөрчлөгдөж болно.

3.1.6. 600 вольтын шугамын тэжээлийн кабель бүр тус тусдаа амперметртэй байна.

3.1.7. Татах хоёр дэд станцыг холбож байгаа 600 вольтын шугамын тэжээлийн кабельд ачааллыг хэмжигч хоёр талын хуваарьтай амперметр тавина.

3.1.8. 600 вольтын тэжээлийн шугам хүчдэлтэй суму тасарсныг мэдээлэх дуут болон гэрлэн дохионы хэрэгсдэлтэй байна.

3.1.9. Цахилгаан татах дэд станц бүрт их чаалын шулуутгагч агрегатыг ажиллагаатгүй болсон үед троллейбусны шугамыг тэжээлээр найлвартэй хамгах чаалтай бэлтгэл шулуутгагч агрегат байна. Тухайн дэд станцад бэлтгэл шулуутгагч агрегат байхгүй бол зэргэлдээх дэд станцын бэлтгэл шулуутгагч агрегатаар троллейбусыг тэжээж болно.

3.1.10. Дэд станцын цотоод хэрэгцээний тэжээлийг лаврах эх үүсвэрийн аль нэгээс хандана. Үүнд:

-6-10 кв-ын бэлтгэл оролтонд холбогдсон цотоод хэрэгцээний хоёрцогч трансформатор

-6-10 кв-ын цуглуулах шинэ холбогдсон цотоод хэрэгцээний хоёрцогч трансформатор ба 5 кв- хүртэл чаалтай 220/380-ын үл хамарах оруулга

Өөрийн цотоод хэрэгцээний тэжээлийн үндсэн эх үүсвэр ажиллагаагүй болсон тохиолдолд тэжээлийг нь сэлгэж үл болох хэрэглэгчдийн чаалтай тэнцүү хэмжээний чаллыг гэмжүүлэх 220/380 вольтын шугамын хүчдэл бүхий үл хамарах оруулга

3.1.11. Цахилгаан татах дэд станцын ажиллаж байгаа төхөөрөмжийн дуу чимээ нь үйлдвэрийн барилгын /СҮНН/ болон эрүүд ахуйн, норм, хөдөлмөр хамгаалалын нүрэмд эвэсэн хэмжээнээс хэтэрэхгүй байх ёстой.

3.1.12. Цахилгаан татах дэд станц бүрийг засвар, үйлчилгээний ажилчдын байр, ариун цэврийн өрөө, диспетчерийн ажлын хувцас хадгадах болон цайны тусгай өрөөтэй байхаар тооцно.

3.1.13. Цахилгаан татах нэг станцын засвар үйлчилгээний ажилчил нь диспетчертэй /диспетчергүй газар троллейбусны комбинатын төлөөлөгчтэй/ шуурхай холбоо барих холбооны техник хэрэгслээр хангагдсан байна. Диспетчерийн холбоо нь хоёроос доошгүй сувагтай байна.

3.1.14. Байнгын диспетчергүй цахилгаан татах нэг станц бүрт гараах зүйлүүд байх ёстой.

-Цахилгаан татах нэг станцын аюулгүй ажиллагааны дүрэм

-Цахилгаан гүйдэлц нэрвэгдэгсэлд анхны тусламж үзүүлэх заавар

-Цахилгаан холболтын ерөнхий схем, хоёртогч хэдхээний /коммутацийн/ схем

-Нэг станцын үйлчлэх хүрээний схем

-Төхөөрөмжид гарсан эвдрэл гэмтлийн бүртгэл

-Аккумуляторын багаретийн ажиглалтын

-Ашиглалтын зааврууд

Ээлжийн ажил хүлээлцсэн, хугацаа, хуваарьдах байгууламжинд хийсэн сэдгэн залгалт, цахилгаан тосголд, автоматүүд, хамгаалах хэрэгслийн ажлын горимын өөрчлөлт, техникийн улирлах ажилтнаас өгсөн шуурхай шийдвэр, ээлжинд гарсан осол зөрчлийг арилгахад өвсөн арга хэмжээ, автоматикжлын болон хамгаалалтын хэрэгсэл, салгах төхөөрөмж, шпалет, тэсгэлдүү"-дүн эвдрэл, гэмтлийг тэмцэгдэх шуурхай ажлын бүртгэл баталсан жагсаалтад орсон сэдбэг хэрэгсэл, гал хамгаалагчууд

-Бүх өрөөний түлхүүр

3.1.15. Байнгын диспетчертэй цахилгааны нэг станцад диспетчергүй станцад байх зүйлүүдээс гадна дор дурдсан нэмэгдэл зүйлүүд байна. Үүнд:

-Дотоон журам

-Албан тушаалын заавар

-Цахилгааны татах нэг станцын тосгог төхөөрөмжийн төлөвлөгөөт засварын график

- Шулуутгагч агрегатын ажиллагааны график, жижүүрийн үүрэг
- Засварын ажлын бүртгэл
- Гал эсэргүүцэх ажиллагааны заавар
- Бүх ерөөний түлхүүр 3 ширхэг байх ба нэг нь нөөцийн зориулалтаар ломболсон шүүгээнд хэцгелэгдэнэ.

3.1.6.Цахилгаан татах нэд станцууцыг удирдах диспетчерийн байранд гараах зүйлүүд байна.

- Байгууллагын потоон журам
- Ашиглалтын бодон ажил элбэн тухавлин заавар
- Цахилгаан татах нэд станцын тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт засварын график
- Хөдөлмөр хамгаалал, галын аюулгүй ажиллагааны дүрэм
- Цахилгаан гүйцээлч нэрвэлгээсгелд анхны тусламж үзүүлдэх заавар
- Цахилгааны холболтын ерөнхий /нэг шугамын/ схем, хоёрдогч коммутацийн схем
- Диспетчерийн тухайн пунктэд харьяалагдах цахилгааны бүх татах нэд станцууцын гэжээлийн схем
- Нэд станцууцын засварын ажлын бүртгэл, ээлж хүдээн авсан, өгсөн байдал, хувьдарилах байгууламжани хийсэн сэлгэн залгалтууд, цахилгаан тоноглол, автоматүүд, хамгаалах хэрэгслийн ажлын горимын өөрчлөлт, удирдлагаас өгсөн шуурхай шийдвэр, ээлжил гарсан осол зэрчлийг эригдахад авсан арга хэмжээ, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг тэмцэгдэх шуурхай ажлын нэвтэр
- Эмийн сан
- Засвар, үйлчилгээний ажлын их бүрэн баражууд
- Гал унграах хэрэгсэл, гал эсэргүүцэх ажиллагааны заавар
- Хөдөлмөр хамгаалад, галын аюулгүй ажиллагааны дүрэмд заагдсан хувь хүний хамгаалах хэрэгсэл
- Диспетчерийн тухайн пунктээс харьяалагдах цахилгаан

татах цэд станцууцны хавдганы гүдхүүрүүд

-Цахилгаан төхөөрөмжинд үзлэг хийх эрх бүхий болон шуурхай шийцвэр өгөх эрхтэй хүмүүсийн нэрсийн мэдээлэл

3.1.17.Цахилгаан хангамжийн алба, цэд станц бүрт гараах зүйлүүд хавдгалагдана.

-Цахилгаан татах цэд станцын план зураг, схем, ажлын зураг нэхь паспортын үндсэн үзүүдэлтүүд

-Цахилгаан татах цэд станцын газар доорхи сүлжээг гусгасан ерөнхий төлөвлөгөө

-Хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтын ажилгүй ажиллагааны нүгэм бүсэл зэвсгээр хүмүүсийн мөндлэгийг шалгасан, сурталт явуулсан, ажилдуулахыг зөвшөөрсөн баримт бичгүүд

-Тоног төхөөрөмжийн зэвсгэн паспорт

- Тоног төхөөрөмж, хамгаалагчийн хэрэгсэлийг шалгах, туршсан акт

- Цахилгаан татах цэд станц, цахилгаанаар хангагч байгууллаагч хоорондын ажлын үндсэн холбоо, ажиллагааны зарчим, тоногдлын үйлчилгээний заагийг тогтоосон акт баримт, гэрээ

3.1.18. 13- 1⁰ кв-ын хувьсах гүйдлийн бэ 600 вольтын тогтмол гүйдлийн шен болон цотоог хэрэглээний трансформатораас гацны хэрэглэгчийг цахилгаанаар хангахыг хориглоно.

3.1.19.Цахилгаан татах цэд станц нь хашаагаар хамгаалагдсан байх бөгөөд газар орон нутгийн байдлаас хамааруулж залгай хийж болно.

3.1.20.Цахилгаан эрчим хүчний зарцуулалтын шуурхай бүртгэл тооцоог квт-цагаар гарах хүмүүс хийж байна.Тооцооны багаж хэрэгсэл, цахилгаан татах цэд станцад байрласан бол цэд станцын шуурхай үйлчилгээний ажилтан

Тооцооны багаж хэрэгсэл нь цахилгааны цэд станцад байрласан бол Улаанбаатар хотын цахилгаан тугам сүлжээний шуурхай диспетчер

3.1.21. Троллейбусны хөдөлгөөнийг 20 минутгаас пээш хугацаагаар саатуулж цахилгаан төхөөрөмжийн хэвийн ажиллагааг зөрчигдвөл /ажилдахгүй болох, гэмтэл гарах/ үзлэг шалтгаалт хийж дараах зүйлийг тусгасан акт тогтооно. Үүнд:

- Гэмтэл үүссэн, үргэлжилсэн шалтгаан
- Хөдөлгөөн саатуулсан /буруутан/
- Үйлчилгээний ажилтнууд зөв ажилласан эсэх
- Хамгаалах, тохируулах автомат тоног төхөөрөмжийн ажиллагааны байдал, гэмтдээс шалтгаалж гарсан тоног төхөөрөмжийн эвдрэл
- Контактын сүлжээнд тэжээл тасалдсан хугацаа
- Гарсан гэмтлийг арилгах талаар звсэн арга хэмжээ

3.1.22. Ашиглалтад шинээр орсон төргөтгөд, шинэтгэл хийгдсэн цахилгаан татах цэд станц нь автоматиклэн харагдлаар бүрэн тоноглогдсон байна. Цахилгаан хангамжийн систем болон ашиглагч байгууллагын бүтцээс хамрааруулж автоматжуулалт, телемеханикийн удирдлага, теледохирлолын хүчин чацлыг тодорхойлно.

3.1.23. Диспетчергүй цахилгаан татах цэд станцад 600 В-ын шугам нь автоматгаар салгагддаггүй бод телемеханикийн удирдлагыг теледохирлолтой гавина. Байнгын ажигчгүй цахилгаан татах цэд станц нь 600 В-ын бэлтгэл шугамуудаар бүрэн нөөцлөгдсөн, автоматаар салгагддаг бод бага хэмжээний телемеханик удирдлагатай байж болох бөгөөд харин цахилгаан татах цэд станцын техникийн байдлыг мэдээлж өгөх автомат теле дохиолол заавал байх шаардлагатай.

3.1.24. Бүрэн хэмжээний телемеханикийн удирдлагатай цахилгаан татах цэд станцад дараах үйлдлүүд хийгдэнэ. Үүнд:

- 6-10 кв-ын тэжээлийн оролт, шулуутгагч агрегатууд, 600 В-ын шугам болон бэлтгэл тэжээлийн таслуурууд, бэлтгэл шинийн сэлгэн залгагчуудын теле удирдлага
- Алсын удирдлагатай болон удирдлагагүй объектын байдлыг мэдээлж байх теле дохиолол

3.1.25. Бүрэн автоматжуулсан үеэ дараах үйлдлүүд хийг-
цэнэ. Үүнд:

- 6-10 кв-ын тэжээлийн оруулгын бэлтгэлийн автомат
залгалт /БАЗ/
- Шулуутгагч агрегатын бэлтгэлийн автомат залгалт
- 600 В-ын шугамын таслуурны автомат дахин залгалт /АДЗ/
- Цахилгаан татах дэд станцын тоогол хэрэгцээний
тэжээлийн бэлтгэлийн автомат залгалт /БАЗ/
- Цахилгаан татах дэд станцын тоогол төхөөрөмжийн авто-
матаар салгах, тэдгээрт гэмтэл гарах үед шууд ба гэрлэн похио
өгөх хэрэгсэл

3.2. Цахилгаан татах дэд станцын тоогол төхөөрөмжид
тавих шаардлага

3.2.1. Тоогол төхөөрөмж, агрегатыг технологийн горимын
дагуу ажиллуулах, бэлтгэл төхөөрөмжүүдийг түргэн хугацаанд
найдвартай залгах ажиллагааг цахилгаан татах дэд станцын
автомат байгууламжууд хангана.

3.2.2. 600 в-ын тэжээлийн шугамыг түргэн үйлчилгээтэй
автомат таслуур болон шугамыг болгоно холболтын гүйцэл, ачаал-
лаас хамгаалах хэрэгсэл бүхий удирдлагатай хувиргуур /управ-
лений преобразователь/ -аар тоноглоно.

3.2.3. Нэг шинэ систем дээр ажиллах хувиргагч агрега-
тууд нь зэрэгцэн тогтвортой ажиллах боломжийг хангасан техни-
кийн үндсэн өгөгдлүүдтэй байна.

3.2.4. 600 в-ын цахилгаан тоноглолын хийц болон схем
нь шугамын таслуурт үзлэг, ээсвэр хийх, түүнчлэн шугамын
тэжээлийг таслахгүйгээр хамгаалалт удирдлагын үүрэг гүйцэт-
гэх удирдлагын хувиргуур, аппарат хэрэгслэлийг холбох боломж-
той хийгцэнэ.

3.2.5. Тогтмол гүйцлийн системийн доторхи газарнуулгад
холболт үүсэхэд шулуутгагч агрегатууд, бусад цахилгаан татах
дэд станцуудын тэжээлийн шугамыг зэрэгцээ ажиллаж байгаа
тэжээлийн шугамын автомат таслуурууд автоматаар таслагдаж

байхаар цахилгаан татах нэд станцын газартуулгын байгууламжийг хийнэ.

3.2.6. Хэт хүчлэлээс шулуутгагчийг хамгаалах хэрэгсэл, шулуутгагчийн шүүгээ, хайсны хаалганы санамсаргүй онгойлгохоос хамгаалсан механик түгжээ, цоож хийж тоноглоно.

3.2.7. Цахилгаан татах нэд станцын хэмжих, шалгах багажны заалтыг тэмдэглэж байгаа хүн хүчлэлтэй байгаа тоног төхөөрөмжид санамсаргүй хүрэх боломжгүй эвд хэмжих, шалгах багалануудыг байрлуулна.

3.2.8. 610 кв-ын тэжээлийн бэлтгэл оруулгын автомат задлагч нь ажлын оролт тээрээ хүчлэл байхгүй блок, таслуур автоматаар салсан үед бэлтгэл оруулгыг задгах ёстой.

3.2.9. Бэлтгэл шулуутгагч агрегатыг автоматаар задлагч нь ажиллаж байгаа агрегат хэт ачаалалтай болох, эсвэл таслуур автоматаар салсан үед /600 В-ын хүчлэлийн нугам газартай холбогдохоос хамгаалсан хамгаалалт ажиллахад автоматаар таслагчаас бусад үед /бэлтгэл агрегатыг задлах ёстой.

3.2.10. 600 В-ын шугамын таслуурын дахин залгах автомат /АДЗ/- нь хэт ачааллаас таслуур таслагдах үед тодорхой хугацаанд олон дахин давтан залгалт хийх, богино холболтоос таслуур таслагдах үед нэг удаагийн давтан залгалтыг тус тус гүйцэтгэх ёстой. Хугацааны релейн хамгаалалт, богино холболтын шалгагчтай 600 В-ын төхөөрөмжинд автомат дахин залгалт хийхтээ гарах үйлдлийг гүйцэтгэнэ.

Үүнд:

-Хэт ачааллаас таслуур таслагдах үед тодорхой дөчилсэн хугацаанд олон дахин давтан залгалт хийх

-Хугацааны гүйдлийн релейн хамгаалалтаас таслуур таслагдсан үед контактын сүлжээний угас хөрсний дараа дахин залгалт хийх, шугамын таслуурын удирдлагын схем нь шуурхай диспетчер телемеханикийн удирдлагаар эсвэл, таслуур салгалттай үед гар удирдлагаар АДЗ-ыг салгах боломжийг хангасан байна.

3.2.11. Дотоод хэрэгцээний ажлын тэжээлийн эх үүсвэр цээр хүндэл байхгүй болох үед бэлтгэл тэжээлийг задрах боломжийг хангана.

3.2.12. Тусгаарлагдсан туйлтай цахилгаан хангамжийн системд ажиллаж байгаа цахилгаан татах цэд станци нь тогтмол гүйцлийн туйл бүрийн тусгаарлагчтыг газартай харьцангуйгаар хянах автомат хэрэгсэл, болон 600 В-ын системд 6-10 кв-ын хүчдэл орохоос хамгаалсан хамгаалалтын төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Сөрөг туйлын шугамд аюулгүй ажиллагааны арга хэмжээг зэрэг туйлын шугамын нэгэн эгил авна.

3.3. Цахилгаан татах цэд станцал хийх үзлэг, техникийн үйлчилгээ:

3.3.1. Цахилгаан татах цэд станцын үйлчилгээг энэ дүрмийн 3.1.3-т заасан ашиглалтын болон эдсэн үүргийн заавар, удирдлагын техникийн бэрмийг бичгийн дагуу гүйцэтгэнэ.

3.3.2. Цахилгаан татах цэд станцын үйлчилгээний горим, ээлжийн ажилчдын тоог цахилгаан хангамжийн систем, автоматжилт, телемеханикжилтийн түвшин, ашиглагч байгууллагын бүтцээс /орон тоо, зохион байгуулалт/ хамрааруулан тогтооно.

3.3.3. Байнгын диспетчергүй цахилгаан татах цэд станцын үйлчилгээг шуурхай засварын ажилчин гүйцэтгэнэ. Шуурхай засварын ажилчин нь эдсэн үүргийн заавар, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллана. Харин тухайн цэд станцын үйлчилгээ хийх хүмүүсийн ажил үүргийг троллейбусны комбинатын тушаалаар батлана.

3.3.4. Троллейбусны контактны сүлжээний хүчдэлийг салгаж цахилгаан татах цэд станцал ажил гүйцэтгэх шаардлагатай бол энэ талаар Троллейбусны комбинатын хөдөлгөөний албатай зөвшөөрөлдцөн байна.

3.3.5. Шугаманд таслуургүй бол салгуураар дараах зүйлийн таслалт, задралт хийж болно. Үүнд:

-Бүрэн ажиллагаатай хэмжүүрлэг хүчдэлийн трансформатор 10 кв- хүртэл хүчдэлийн 320 кв-а хүртэл чадалтай хүчний трансформаторын соронзжуулалтын гүйцэл

-6-10 кв-ын цуглуулагч шашын цэнэглэх гүйцэл
 -I дүгээр хүснэгтэнд зэвсэн урт, хөнцлөн огтлолт, ажлын хүчдэл бүхий кабелийн цэнэглэх гүйцэл:
 /Ачаадалгүй ба газартай холбоогүй үед/

Хүснэгт № I

Үзүүлэлт	Ажлын хүчдэл												
	I	6						10					
Хөнцлөн огтлолт мм ²	бүх	240	185	150	120	90	70	240	185	150	120	90	70
урт, км-ээс илүүгүй	нормчлогдсон огтлолын доггүй	3,9	4,3	4,5	4,9	5,4	5,7	1,2	1,2	1,2	1,4	1,5	1,7

-Зэрэгцээ ажиллаж байгаа эсрэг потенциалтай өөр кабель байгаа тохиолдолд 600 В-ын эсрэг потенциалтай тэжээгч кабелийн ачааллын гүйцэл

3.3.6. АДЗ- болон гүйцлийн хугацааны релейн хамгаалалт, богино холболтын бага гүйцлээс хамгаалах өөр хэрэгслээр тоноглогдоогүй 600 В-ын шугамын таслуур автоматаар таслагдах д шуурхай диспетчер шугамаас гэмтлийн тухай мэдээ аваагүй байхаас өмнө таслуурыг хоёроос дээшгүй удаа туршилтын давтан залгалт хийхийг зөвшөөрнө.

Эхний удаа таслагдсанаас хойш 0,5 минутын дараа, хоёр дахь удаа таслалт богино холбоосоос үүссэн байвал 3 минутын дараа тус тус залгалт хийнэ. Гүйцлийн хугацааны релейн хамгаалалт, богино холболтын бага гүйцлээс хамгаалах хамгаалалтын өөр хэрэгслээр тоноглогдсон боловч АДЗ- байхгүй тохиолдолд шугаман таслуур автоматаар тасрахад таслалтаас хойш 3-4 минутын дараа нэг удаа туршилтын давтан залгалт хийж болно.

" 3.3.7. Хэт ачааллаас болж шугамын таслуур автоматаар тасарвал хэт ачааллын байрлаас хамгаарч дахин залгалтыг 2-оос дээш удаа хийж болно. АДЗ-аар төхөөрөмжлөгдсөн 300 В-ын шугамын таслуур автоматаар таслагдах, хаагдахад шуурхай диспетчер шугамаас гэмтлийн тухай мэдээ авахаас өмнө нэг удаагийн давтан залгалт хийж болно.

Гүйцлийн хугацааны релейн хамгаалалт, богино холболтын бага гүйцлээс хамгаалах хамгаалалтын өөр хэрэгсэлээр тоноглогдсоогүй таслуурт таслалтаас хойш 0,5 мин, тоноглогсон бол 3-4 минутын гэрээ цэвтэн эвдгэлт хийнэ.

3.3.8. Автоматаар таслагддаг төхөөрөмжийг цэвэр эвдэх боломжийг тодорхойлсон зааврууцыг боловсруулж гаргасан байна.

3.3.9. Цахилгааны татах дэд станцын шуурхай диспетчер нь тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, автомат таслалтын тухай цахилгааны төр диспетчер болон хариуцсан албан тушаалтан нэрт яаралтай мэдэгдэж тэдний өрсөн заавраар ажиллана.

3.3.10. Цахилгаан татах дэд станцын тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, туршилтыг троллейбусны комбинатаас тогтоосон хугацаанд хийх бэ энэ нь улсын эрчим хүчний хяналтын албанаас баталсан цахилгаан төхөөрөмжийг турших норм, троллейбусны цахилгаан татах дэд станцын тоног төхөөрөмжийн засварын ажлын зааварт заасан хэмжээнээс бага байж болохгүй.

3.3.11. Байнгын диспетчертэй цахилгаан татах дэд станцын тоног төхөөрөмжийн хийх үзлэгийг таслалт хийхгүйгээр хоногт нэгээс доошгүй удаа, байнгын диспетчергүй татах дэд станцад 7 хоногт нэгээс доошгүй удаа хийнэ.

3.3.12. Цахилгаан татах дэд станцад ашиглалтын болон гвл, хөдөлмөр хамгааллын осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх үзүүдэн, зуралт хуудас тавьсан байна.

Трансформаторын ерөөний цоторхана, хаалга, хайрцарнууд төхөөрөмжийн шүдээ, удирдлагын самбаруудад холболт, аппаратын нэрийг троллейбусны комбинатын бүх дэд станцуудад мжил байхаар бичиж халсан байна. /дугаарлаж болохгүй/

Таслах эвдгэх аппаратын намжуулга, ушарлах тугжүүр, товчлуурын пэргэд аппаратын ажлын байрлалыг зэвсэн бичлэг хийсэн байна. 600 В-ын хүчдэлтэй хоёрлогч коммутацийн аппаратыг "600 В" гэсэн бичлэг эсвэл хүчдэл байгааг зэвсэн тэмдгээр ялгасан байна.

3.3.13. 600 В-ын шугамын таслуур түр ачааллын үед сарв 10-аас илүүгүй удаа таслагдахаас тооцолсон цахилгааны таслоог үндэслэн уг таслуурын ажиллаж эхлэх үеийн гүйцлийг сонгом авна.

Хэрэв энэ гүйцэл согоно холбоотын гүйцлийн хамгийн бага хэмжээнээс хэтэрч байвал контактын сүлжээний угсыг шатахаас хамгаалсан хамгаалалтын нэмэгдэл тохөөрөмжийг шугамын таслуурт тавьж огно. Бэлтгэл таслуурын ажиллаж эхлэх үеийн гүйцэл тухайн лэц станцын шугамын таслуурын ажиллаж эхлэх үеийн хамгийн их гүйцэлтэй тэнцүү буюу их байна.

3.3.14. Татах ачааллын түүхэлт өөрчлөлтийг тооцоолж 6-10 кВ-ын оруулгын/их/ гүйцлийн хамгаалалтын өхмөлөж эхлэх үеийн гүйцлийг сонгом авна.

4. Контактны сүлжээ:

4.1. Ерөнхий шаардлага

4.1.1. Троллейбусны контактны сүлжээ нь парвах үндсэн элементүүдээс бүрдэнэ. Үүнд:

а/ Баганат байгууламжуур

б/ Тулгуурууд ба контактны сүлжээг тогтоох бэхэлгээний троссын систем /утсан эсвэл ган татлага, /

в/ Дүүжин тоноглол ба тусгай зориулалтын эн ангиуд

г/ Төжээлийн болон хүчитгэсэн намжуулагч утас /туслах/

4.1.2. Контактны сүлжээг тогтоож өлгөх систем, чиглэл нь их ээсвэр хийсний дараа өөрчлөгдсөн байвал троллейбусны комбинатын тогтоосон журмын пагуу ашиглалтанд хүдээн звах ёстой. Контактны сүлжээний угсралт хийсний дараа гүйцэтгэгч байгууллага хүдээлгэн өгөх бэлтгэлийн ажлыг хариуцна.

4.1.3. Контактын сүлжээний хүчдэлтэй байгаа элементүүдийн ойролцоо ажил гүйцэтгэгчид албан байгууллагуудад контактын сүлжээний шинэ хэсэгт хүчдэл өгөхөөс 5 хоногийн өмнө утсаар эсвэл албан бичгээр мэдэгдсэн байх ёстой.

4.1.4. Контактын сүлжээний барилга угсралтын ажлыг дуусгаж, хүчдэл өгөхөд бэлэн болгож, ажлаагчийг ажлын байрнаас нь холдуулсан буюу энэ талаар анхааруулсан тухай мэдэгдэх хуудсыг барилгын болон угсралтын байгууллагуудаас албан ёсоор хүлээн авсны дараа троллейбусны комбинатын цахилгаан хангамжийн албаны даргын зөвшөөрлөөр контактны сүлжээнд хүчдэл өгнө. Цаашид явагдах бүх ажиллагааг цахилгааны ажлуурчдын монтёрын завсраар явуулна. Контактын сүлжээнд хүчдэл өгснөөс эхлэн хүчдэлтэйг тооцно. Барилгын болон угсралтын байгууллагууд нь контактны сүлжээнд эхний хүчдэл эелгээний дараа Хотын цахилгаан тээвэрт ажиллах арга техникийн мурчин цагуу цахилгааны ээлжийн диспетчерийн зөвшөөрлөөр контактны сүлжээнд ажил хийж болно.

Контактын сүлжээний бэхлэлт

4.1.5. Алслагдтууд нь баганууд дээр бүх төрлийн энгийн хатуу бэхлэгчүүд 25-30 м, барилгын ханан дээр 25 м, ердийн налуу утсан татуургануудад 35-40 м, хэвсэг тэнцвэртэй буюу тэнцвэргүй хэлхээнүүдэд 45-50 м, тээврийн энгийн хатуу бэхлэгчүүдэд 4 м хүртэл байх ёстой.

4.1.6. Троллейбусны комбинатын нэгдсэн журмын цагуу контактны сүлжээг замын хүчилтэн гадаргуугаас 5,7-5,8 м, өндөрт $\pm 0,1-0,15$ м хэлбэлзэлтэйгээр бэхэлнэ.

Контактны сүлжээний бэхлэгчид өндрийг пор мувьцсан нөхцөлд багасгаа болно.

I. Денегийн барилга дотор, троллейбус завсарын газар, завсруудад 5,2 м хүртэл

2,20 % налуутайгаар гүүрэн постууд, хонгийн дотор 4,2 м хүртэл.

Тайлбар: Контактны сүлжээг 40 % налуутай бэхэлсэн тохиол-

полд троллейбусны хөдөлгөөний хурцыг заавал 15 км/цаг хүртэл бууруулна. Бүгрэн цор 4,2 м өндөрт бэхлэгдсэн контактын сүлжээг тухайн гүүрийг цахин шинэчлэлт хийх хүртэл ашиглаж болно.

4.1.7. Троллейбусны шугам нь цахилгаанхаагүй төмөр замтай нэг түвшинд огтлолцох үед бэхлэгээний өндөр контактын сүлжээний утасны бэхлэгээ, холбох цэгийн хоорондох зайг цаг агаарын тааламжгүй нөхцөл, ачаалалыг /салхи, хальтйргээ, гуулгаа/ тооцон контактын сүлжээний утас төмөр замын рельсээс 5,75 м-ээс ноошгүй өндөрт байхээр байрлуулж бэхэлсэн байна.

4.1.8. Контактны сүлжээ бусад байгууллагуудын цахилгааны болон холбооны агаарын шугамын огтлолцол нь барилгын оноо морцөгдөж байгаа норм, дүрэм, стандарт, цахилгаан тоног төхөөрөмжүүдийн байгууламжын дүрэм заавруулын дагуу хийгдэж байх шаардлагатай.

4.1.9. Троллейбусны контактын сүлжээнд нэмэх, хасах туйлтай утаснуудын хоорондын зай нь бэхлэгээний загвараас хамаарч 500-700 мм, тусгай эц ангид холдох бүрэлдэхүүнд ойртох хэсэгт 400-700 мм байх ёстой.

4.1.10. Контактны сүлжээний хасах утсыг хөдлөх бүрэлдэхүүний явах чиглэлийн дагуу заавал баруун талд байрлуулна. Тайлбар: Онцгой нөхцөлд контактын сүлжээний утаснуудын бэрлэлийг эсрэгээр өөрчилж болно. Энэ үед бүх тоноглолыг улаан өнгөөр бүтэх ба өөрчлөсөн гээрт тусгайлан анхааруулсан тэмдэг тавих хэрэгтэй.

4.1.11. Троллейбусны шугамын эргэлтийн хэсэгт хөдөлгөөний хурцыг бууруулахгүйн тулд контактын сүлжээний утасны хугарлын өнцгийг 4 градусас дээшгүй байлгах шаардлагатай. Уулзвар болон шугамын тойруу хэсэгт муруй баригчийг хэрэглэсэн үед контактын сүлжээний утасны хугарлын өнцөг нь 8-45 градус байж болно. Замны уулзвар эргэх хөдөлгөөний үед хөдөлгөөний хурцыг бууруулах шаардлагатай нөхцөлд контактын сүлжээний хугарлын өнцөг 8 градус хүртэл байж болно.

Контактын сүлжээ нь онцгой ширүү бэхлэгдсэн /троллейбусны депогийн зогсоол, зэвсгийн газар, заводад/ нөхцөлд, хөдлөх бүрэлдэхүүний хурд 5 км/цагаар хязгаарлагдах бөгөөд контактын сүлжээний хугарлын өнцөг нь зэс утастай үед 16 градус, ган, хөнгөн цагааны хайлшин утастай үед 12 градус хүртэл байж болно.

Багана тэдгээрийн бэхэлгээний төхөөрөмж:

4.1.12. Төмөр бетон баганууд нь урьдчилан хийсэн арматуртай байхаас гадна мөн нэг зэрэг нурахаас хамгаалсан хүчлэлгүй арматуртай байх ёстой.

4.1.13. Баганы төрлийг үйлчилж байгаа ачааллаас хамааруулан сонгох авна. Баганыг анкерын троссоор татаж бэхлэх бөгөөд анкерын троссыг авто замын хүчилтэас 5 м, явган хүний замаас 3 м-ээс доошгүй өндөрт тус тус байрлуулна. Баганад анкерын тросыг бэхлэх хэсэгт чангалагч төхөөрөмж бүхий тусгаарлагчийг заавал хийсэн байх шаардлагатай.

4.1.14. Багана болон контактын сүлжээний утаснуудын хооронд хоёр үе шаттай тусгаарлагч байх учир тусгай газардуулга шаардлагагүй. Төмөр баганыг газардуулагч болгон хэрэглэхийг хатуу хориглоно.

4.1.15. Барилга, байгууламжийн хананд контактын сүлжээг бэхлэхдээ дуу, шуугиан намхатгагч хэрэгсэл тавьсан байвал зохино.

4.1.16. Барилгын өнцөг, цонх, хаалганы суулгацнаас бэхлэгээний цэг хүртэлх зай нь 50 см-ээс багагүй байна.

Контактын сүлжээний тусгаарлагч :

4.1.17. Контактын сүлжээний хүчдэлтэй байгаа төхөөрөмжүүдийг багана, барилга байгууламж, холбоо, гэрэлтүүлгийн болон бусад цахилгааны шугамуудтай холбох тохиолдолд хоёрсоо доошгүй үе шаттай тусгаарлагч хэрэглэнэ. Троллейбусны шугамд нэг үед шаттай тусгаарлагчийг зөвхөн контактын сүлжээ нэмэх, хасах туйлтай утаснуудын хооронд хэрэглэхийг зөвшөөрнө.

Тайлбар: 1. Модон багана, дуу намхатгагчийг тусгаарлагч гэж тооцожгүй.

2. Контактын сүлжээг багана, барилга байгууламж, газраас

тусгаарласан байх шаардлагатай.

4.1.18. Ердийн хүчдэлтэй холбох цугам нь ойролцоох биесээс доорх зайд оршино.

- Баганын төхөөрөмжүүдээс хэвтээ чиглэлд 1,5 м
- Барилгын гадаргуу, цонхны суулганаас хэвтээ чиглэлд 2 м
- Тус аарлагчтай тулгууруудаас бүх чиглэлд 0,25 м
- Таримал модноос хэвтээ чиглэлд 1,5 м
- Модны мөчрөөс /цасгүй, хальтиргаагүй, салхигүй, тохиолдолд/ 1 м
- Инженерийн барилга, байгууламжийн төмөр хийцээс 0,2 м

Троллейбусны депогийн хаалга цахилгаан тусгаарлагч материалаар /дельта модлог, эсвэл текстолит/ хүрээлэгдсэн байвал контактын сүлжээ э тусгаарлагчийн гадаргуунаас 200 мм-ээс доошгүй зайд байна.

4.1.19. Троллейбусны контактын сүлжээ огтлолцсон тохиолдолд троллейбусны шугамны барилгын норм, дүрмийн дагуу сүлжээний нэмэх, хасах туйлтай утаснуудын хооронд тусгаарлагч хийсэн байх шаардлагатай.

4.1.20. Троллейбусны контактын сүлжээ төмөр байгууламж /8 м-ээс багагүй өндөр/ дотуур орох тохиолдолд төмөр байгууламжийн хэсгийг дагуу нь 1-1,2 м өргөн, 50 мм өндөр модон хаалтаар доторлоно. Байгууламжийн доторлогоо нь төмөр байгууламжийн ирмэгээс хоёр тийшээ 0,25 м цухуйж гарсан байх ёстой. Хэрвээ доторлогоо нь сараалжин хэлбэртэй байвал контактын сүлжээний утас бүрийн дээр 250 мм ээс багагүй өргөнтэй банз байрлуулах бөгөөд энэ нь контактын сүлжээний утаснаас мултарч салсан гүйдэл хүлээн авагчийн тулгуурыг төмөр байгууламжинд хүрэхээс урьдчилан сэргийлж чадахар хэмжээтэй байвал зохино. Бетон болон чулуун байгууламжинд доторлогоо хийх шаардлагагүй.

4.1.21. Контактны сүлжээний ердийн болон гүжжин бэхэлгээний татуургын бүх хүзүүр сүлжээний ойролцоо байх тохиолдолд тусгаарлагч заавал хэрэглэнэ.

4.1.22. Контактны сүлжээг бэхлэх хөндлөн гинжин бэхэлгээний татуургын урт 0,5 м-ээс багагүй байна.

4.1.23. Троллейбусны контактын сүлжээний утаснаас тусгаарлагчтай чангалагч хүртэлх зай 2 м-ээс сэтгүү байна.

4.1.24. Троллейбусны контактын сүлжээтэй огтлолцож байгаа хөндлөн бэхэлгээнүүд нь сүлжээнээс 0,7 м-ээс багагүй зайд байрлана. Энэ зай оорчлогдож байхаар бол хөндлөн бэхэлгээнүүдийг тусгаарлагчтай хатуу татуургаар холбоно.

Контактын сүлжээний утас:

4.1.25. Контактын сүлжээнд $35,100 \text{ мм}^2$ хөндлөн огтлолтой зэс утсыг хэрэглэнэ. Харин депогийн зогсоолны талбай, троллейбус засварын газар, заводад /хөдөлгөөн багатай шугамд/ ПСКА 80/180 маркийн 65 мм^2 хөндлөн огтлолтой ган, хөнгөн цагааны хайлшин утсыг хэрэглэж болно.

4.1.26. Контактын сүлжээний утасны гүйдлийн дундаж нягтрал хэвийн горимонд 3 А/мм^2 , албадаг горимын үед $6,5 \text{ А/мм}^2$ байна. Ослын хэд орчим агаарын температур 30° С хүртэл байхад $0,5$ цагаас дээшгүй хугацаанд мөн хүйтний улиралд бүтэн хоногээр гүйдлийн нягтрамыг 7 А/мм^2 хүртэл ихэсгэж болно. ПСКА 80/180 маркийн ган, хөнгөн цагааны хайлшин утсан дахь гүйдэл хэвийн горимонд 525 А -аас их байж болохгүй. Ослын нэгцэлд 750 А хүртэл гүйдэлтэй байж болно.

4.1.27. Троллейбусны контактын сүлжээ нь огуурийн дагуу цахилгаан секцтэй нээ утсаар /дугагаситель/ -тай олон тусгаарлагчуудаар тоноглогдсон байна. Тусгаарлагчийг хөндлөн бэхэлгээнүүд эсвэл тусгай бэхэлгээнд байрлуулсан байна.

4.1.28. Троллейбусны шугамны хэвтээ чиглэлд олон секцтэй тусгаарлагчуудыг байрлуулна. Зарим тохиолдолд 30% налуутай 100 м -ээс багагүй радиустай тойруу шугаманд байрлуулахыг зөвшөөрнө.

4.1.29. Троллейбусны контактын сүлжээний тэжээгч утас нь сүлжээний тэжээлийн цэгт гүйдэл дамжуулагч хавчаарын тусламжтайгаар 95 мм^2 -аас багагүй огтлолтой тусгаарлагчтай уян зэс утсан холбоосоор холбогдсон байна.

4.1.30. Троллейбусны хоёр утастай сүлжээ өөр хоорондоо $300-500 \text{ м}$ тутамд нэг утасны хөндлөн огтлолоос багагүй огтлолтой утсаар холбогдоно. Мөн тунгшлэн эхний хоёр алслагтын хувьд олон секцтэй тусгаарлагч бүхий хоёр талд утас хоорондын хол-

боосыг байрлуулах зайлшгүй шаардлагатай сумны бэлчир, эргэлтийг утас хоорондын холбоосоор ашиглаж болно.

4.2. Уулзварын болон автомат /жолоочийн удирдлагаар ажиллах / сум

4.2.1. Депогийн зогсоолыг талбай, троллейбусны засварын газар, заводын дотор салбарласан контактын сүлжээнд суман зангилгааны төхөөрөмжийг заавал хэрэглэх шаардлагагүй.

4.2.2. Сумыг контактын сүлжээний хэвтээ чиглэлд 20%-иас дээш налуутай замын дагуу хэсэгт байрлуулна. Харин онцгой тохиолдолд 30 % хүртэл налуутай өгсүүр замд байрлуулахыг зөвшөөрнө.

4.2.3. Автомат сумыг троллейбусны уртын хэмжээнээс хамааруулж замын уулзвар, явган хүний гарц өнгөрөхөөс өмнө тодорхой зайд байрлуулна. Троллейбусны урт 12 м хүртэл байвал 20 м, уртасгасан зайгаатай троллейбусанд 30 м-ээс доошгүй зайд байрлуулна. Уулзварын сумыг замын уулзвар, явган хүний гарцны цаана 10 м-ээс доошгүй зайд тавина.

4.2.4. Жолоочийн удирдлагаар солигддог сумны баруун талын чиглэл нь байнга чөлөөтэй байна. Жолоочийн удирдлагаар зүүн талын чиглэлд сум орох бөгөөд троллейбусыг явж өнгөрсний дараа анхны байрлалдаа дахин шилжинэ.

4.2.5. Сумын зангилгаа бүр нь ердийн болон тусгай хөндлөн бэхэлгээн дээр угсрагдах боловч нэг хөндлөн дээр хоёрдоо ядуу сумны зангилгаа угсрахыг хориглоно.

4.3. Контактны сүлжээнд хийх техникийн үйлчилгээ, үзлэг засвар:

4.3.1. Троллейбусны контактын сүлжээний үзлэг, үйлчилгээ, засварыг тогтоосон хугацаанд зааврын дагуу тогтмол хийж ашиглалтын найдвартай ажиллагааг хангана.

4.3.2. Контактны сүлжээний техникийн үйлчилгээ засварт дор дурьдсан техникийн баримт бичгийг мөрдөнө. Үүнд:

-Контактын сүлжээний тэжээлийн схем, түүний хэсэглэсэн зураглал

-Тэжээлийн кабелийн гаргалгаа, багана, тусгай эд анги, секцтэй тусгаарлагч, байгууламжийг тусгасан контактыр сүлжээний схем, техникийн паспорт

-Хотын цахилгаан тээврийн аюулгүйн техникийн дүрэм, холбооны төхөөрөмжийн дүрэм

-Техникийн болон албан үүргийн зааврууд

-Ашиглалтын бүртгэл

-Контактын сүлжээний засварын график

-Хамгаалах багаж хэрэгсэл, тэдгээрийг шалгаж туршсан тухай акт

-Контактын сүлжээний засвар тохируулгын бүртгэл

-Контактын сүлжээний гэмэлийн акт

-Нэг хэвийн маягт, албан хуудас бичиг бичиг

4.3.3.Контактын сүлжээнд засвар хийх замын орчинт хотын цахилгаан тээврийн аюулгүйн техникийн болон замын хөдөлгөөний дүрмийн дагуу явдал хийж хамгаалсан байх шаардлагатай.

4.3.4.Контактын сүлжээний засварыг автомашины хөдөлгөөн хааж хийх шаардлагатай бол засварын бригадын ахлагч засвар эхлэхээс нэгээс доошгүй хонгирын өмнө хөдөлгөөний албатай хөдөлгөөн хааж, ажлыг эхлэх, дуусгах хугацааг тохиролцоно.

4.3.5.Хэрэв контактын сүлжээний утсанд автомат тохируулгын төхөөрөмж тавигдаагүй бол уг сүлжээг бөрчилж шинэчлэх хүртэл агаарын температурын нөхцөлөөс хамааруулж жилд 2-оос доошгүй удаа тохируулга хийх бөгөөд таталтын хүч нь зэс утсанд $45-125 \text{ ГПа} / 4,5 - 12,55 \text{ кгс/мм}^2 /$ байна. Утасны бэхэлгээний төрлөөс хамаарч тохируулга янз бүр байна. Үүнд:

-Хатуу буюу харас хатуу бэхэлгээтэй утсанд $45-125 \text{ ГПа} / 4,5-12,5 \text{ кгс/мм}^2 /$

-Ердийн гинжин болон ердийн гогцоо бэхэлгээтэй утсанд $35-130 \text{ ГПа} / 3,5-13,0 \text{ кгс/мм}^2 /$

4.3.7. Траллейбусны комбинатна зөвлөөрөлгүйгээр контактын сүлжээний бэхэлгээ, багана тулгуур дээр өөр албан бай-

гууллага тоног төхөөрөмж байгуулахыг хориглоно.

4.3.8. Троллейбусны контактын сүлжээний бэхэлгээний эд ангиуд дээр гаднын байгууллага тоног төхөөрөмж бусад зүйлийг байрлуулбал бэхэлгээний ангиудын бүрэн бүтэн байдлыг троллейбусны комбинат, төхөөрөмжийнхөө бүрэн бүтэн байдлыг гадны байгууллага тус тус хариуцна.

4.3.9. Контактны сүлжээний утасны дараах нөхцөлд солино.
 Үүнд . МФ-85 маркийн эсэ утасны хонцлон огтлолын өндөр нь 9,1 мм байх бөгөөд тэр нь 15 хувь хүртэл элэгдсэн бол
 - МФ-100 маркийн утасны хонцлон огтлолын өндөр нь 9,5 мм байх бөгөөд тэр нь 16 хувь хүртэл хувиар элэгдсэн бол
 - Утас бэхэлсэн цэгүүдийн хооронд байгаа хавчаарын 75 хувь нь элэгдсэн, эсвэл гүлэгцөж хайлсан бол
 - Өндөр температурны үйлчлэлд эс болж утасны механик шинж чанар өөрчлөгдсөн

4.3.10. Контактны сүлжээний утасуудыг тулгаж холбосон хавчааруудыг сүлжээ дүүжлэх бэхлэсэн цэгээс 5 м-ээс багагүй зайд байрлуулна.

Амслалтын аль ч хэсэгт эсэ утасны хүйтнээр тулгаж гагнахыг зөвшөөрнө. Гагнасны баг бэх нь холбогдож байгаа утасны баг бэхээс дутуугүй байх шаардлагатай.

4.3.11. Хонцлон бэхэлгээ эсвэл чангалалт тасарсан тохиолдолд тэжээлийн болон хүчитгэгч /туслах/ утаснууд нь хавиралдахгүй байх нөхцөлийг хангасан байна.

4.3.12. Троллейбусны гүйдэл хүлээн авагч дээрхи хүчдэл нь стандартын шаардлагад зохирсон байх хэрэгтэй.

4.4. Техникийн түргэн тусламжийн зохион байгуулалт :

4.4.1. Техникийн түргэн тусламж нь . контактын сүлжээнд гарсан өвдөр, гэмтлийг тээврийн хэрэгслэлийн хөдөлгөөнийг удаан саатуулахгүйгээр богино хугацаанд шуурхай засварлаж байхаар зохион байгуулагдах ёстой.

4.4.2. Цахилгаан хангамжийн албаны ашиглалтын болон жижүүрийн бригадууд нь техникийн түргэн тусламжийн үүргийг гүйцэтгэнэ.

4.4.3. Техникийн түргэн тусламжийн бригад нь цахилгааны диспетчерийн эсвэл захиргааны шуурхай удирдлагыг зохицуулах эрхтэй төлөөлөгчийн шууд удирдлаганд ажиллана.

4.4.4. Техникийн түргэн тусламжийн бригадын мэдэлд засвар үйлчилгээг хийхэд шаардагдах багаж төхөөрөмж, сэлбэг, материал, хамгаалах хэрэгслэлээр иж бүрэн тоноглогдсон өргөтгч тавцантай, автомашин /автовышка/ байна.

4.4.5. Техникийн түргэн тусламжийн бригадын /ТТБ/ тээврийн бүх хэрэгсэл нь хоёр тавын холбооны хэрэгслэлээр тоноглогдсон байна.

4.4.6. Троллейбусны комбинатын ажилтан бүр троллейбусны хөдөлгөөнд гарсан саатлыг арилгахын тулд техникийн түргэн тусламжийн бригадаас тавьсан асуудлыг шуурхай шийдэж өгнө. Техникийн түргэн тусламжийн бригадын ажил гүйцэтгэх хэсэгт хөдөлгөөний албаны шугамын ажилтнууд байрлах шаардлагатай үед троллейбусны хөдөлгөөнийг зохицуулна. Цахилгааны диспетчер нь шаардлагатай үед сэргээн засварлах ажилд холбогдох мэргэжлийн ажилтныг цахилгаан хангамжийн албанаас томилж ажиллуулах эрхтэй.

4.4.7. Техникийн түргэн тусламжийн бригад нь хотын цахилгаан тээврийн аюулгүйн техникийн дүрмийг хатуу мөрдөж ажиллана.

4.4.8. Техникийн түргэн тусламжийн бригадыг контактын сүлжээний мастер удирдана. Хэрэв хэдэн техникийн түргэн тусламжийн бригад нэг зэрэг ажиллах шаардлагатай нөхцөлд бригадын дарга /мастер/ эсвэл тусгайлан томилогдсон захиргааны техникийн ажилтнууд удирдана.

4.4.9. Контактны сүлжээний гэмтлийн байдлаас шалтгаалж сэргээн засварлах ажлыг 2 үе шаттайгаар гүйцэтгэж болно.

1. Тээврийн хэрэгслэлийн хөдөлгөөнийг зогсоохгүйгээр хурдыг хязгаарлаж сүлжээг яаралтай сэргээн засварлах

2. Ажлын хэмжээ, байрлаас хемааруулж мөрдөгдөж байгаа заавар дүрмийн дагуу сүлжээг хугацаанд нь бүрэн сэргээн засварлах.

4.4.10. Контактын сүлжээний гэмтсэн цэг орчимд тавигдсан гаднын байгууллагын төхөөрөмж, хэрэгсэл, шугам сүлжээ бусад зүйлс нь гэмтийг арилгахад саад учруулж байвал техникийн түргэн тусламжийн бригад тэдгээр саадыг арилгах эрхтэй.

5. Кабелийн шугам:

5.1. Ерөнхий шаардлага

5.1.1. Троллейбусны кабелийн шугамын байгууламжуудад: цахилгаан татах дэд станцаас троллейбусны контактн сүлжээ /нэмэх, хасах, потенциалтай кабелиуд/ хүртэл 600 вольтын тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам, кабелийн байгууламжууд /гаралт, кабелийн хайрцаг, шүтгээ, контактн сүлжээнд холбох цэг/, татах дэд станцуудыг тэжээх зориулалттай, 6-10 кв-ын хэвийн хүчдэлтэй хувьсах гүйдлийн шугам, цахилгаан татах дэд станцын дотоодон хэрэгцээний 0,4 кв-ын хэвийн хүчдэлтэй хувьсах гүйдлийн шугам зэрэг төхөөрөмж байгуулж, хамаарагдана.

5.1.2. Кабелийн шугамын байгууламжуудын бүтэц, ашиглалт нь троллейбусыг цахилгаанаар бүрэн хангах зориулалттай бөгөөд доорхи шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

-Улсын эрчим хүчний хяналтын ерөнхий албаны заавар

-Цахилгаан тоног зохиоомжийн техникийн зюулгүй ажиллагааны дүрэм

-Газар доорхи металл байгууламжийг гүйдлийн зөврэлтээс хамгаалах дүрэм

5.1.3. Кабелийн шугамд дараах бичиг баримт заавал байх ёстой. Үүнд:

1-Кабель шугамын батлагдсан схем

-Кабелийн трассыг оорчих болсон шалтгаан, зөвшөөрсөн албан байгууллагын нэр, хугацаа, үхнтэй холбогдуулан хийгдсэн ажлын жагсаалтыг тэмдэглэсэн бүртгэл

-Трассыг дагуух орчны барилга байгууламж, шугам сүлжээний нягтаас хамааруулан 1:200 буюу 1:500 масштабтай хийгдсэн трассын гүйцэтгэлийн зураг

-Гүйцэтгэлийн зураг дээр шугамын трассыг түүний бүх уртын дагуу барилдсан байгын барилга байгууламжууд буюу зорчуд

хийсэн тэмцэгтэй харьцуулсан байх.

-600 в, 0,4 кв, 6-10 кв-ийн кабель шугамын кабелийн бүртгэл, дайр ажлын актууд, эдгээрийн дотор кабель нь газар доорхи барилга байгууламж шугам хоолойтой эртлэмцсэн ойртсон тухай акт

-Дамартай кабелийн байдал тухай болон үзүүрийн хийцийн байдалд тогтоосон акт, шаардлагатай тохиолдолд зарим дамруудыг онгойлгож үзсэн тухай протокол, кабелийг үйлдвэрлэгч заводаас шалгасан тухай протокол.

-Кабелийг өвлийн хүйтэнд, утгарсан бол кабелийг хэрхэн халаасан тухай протокол.

-Төнгөмөл гүйцлээс кабелийг хамгаалах талаар хийгдсэн ажлын акт

5.1.4. Контактны сүлжээний янз бүрийн цагт кабелийн гаргалгааг салган эвэрлэх, ууршилт, хэмжээнд бодон нөөц кабелийг залгах зорилгоор салган залгааг хийх мунхаг байгуулах, буюу салган залгалтын төхөөрөмж, тавих шаардлагатай.

5.1.5. Эсрэг, сөрөг потенциалуудтай кабелиудад нэг гол жилтэй хуягласан кабелиудыг ашиглах бөгөөд энэ нь хоёроос доошгүй хяналтын жилтэй байх шаардлагатай. Кабель шугамыг өөрчлөх хүртэл тавигдсан гурван жилтэй кабелийг ашиглаж болох бөгөөд мөн гүйцлээс хяналтын жилгүй нэг жилтэй кабелийг ашиглах болно.

5.1.6. Кабелийг барилгын суурь, гүлдмэй, бохир усны шугам, хоолойноос 0,6 м зайд явган хүний замд дор хөрсөнд сунгаж тавих ёстой.

5.1.7. Кабелийг тэгшлэсэн тэмцэлт газрын гадаргуугаас кабелийн бүрхүүл хүртэл 0,7 м-ийн гүнд тавина.

5.1.8. Хөрсөнд сунгаж тавьсан 600 В-ийн кабель нь механик хэмжээс хамгаалсан нэг хо тоосгоос эсвэл хавтангаар хамгаалагдсан байна. Цагаан тоосго, шааргаар хийсэн хөндий тоосго хэрэглэхийг хориглоно. Эсрэг өөр ямар байгууллагуудыг ашиглах байгаа 10 кв-хүртлэх хүдэлийн кабелиуд /10 кв хүчдэлийн кабель орсон/ хөрсөндөө 10 мм зайтай байх бөгөөд

түүнчлэн хүчний болон холбооны кабелиудын хоорондын зай 500 мм-ээс багагүй байх шаардлагатай.

5.1.9. Цахилгаанжуулсан төмөр замтай кабелийн шугам огтлолцсон тохиолдолд тэдгээрийн доогуур цахилгаан дамжуулцаггүй материалаар хийгдсэн хослойгоор сүвлэж гаргах шаардлагатай. Хоолой нь 2 талаас 2 м-ээс доошгүй, эсвэл ус зайлуулах сүвгийн хоёр захаас 1 м-ээс доошгүй илху гарсан байна.

5.1.10. Кабелийн шугам нь төмөр болон авто зам, гудамжуудтай огтлолцож байгаа хед кабелийн шуудуутгийн гүн нь түүрийн гадаргуугаас эсвэл төмөр замны рельсийн доод талаас 1 м-ээс доошгүй, ус зайлуулах сүвгийн эрээлөөс 0,5 м-ээс доошгүй зайд байвал зохино.

5.1.11. Цахилгаан тоног төхөөрөмжийн байгуулалтын дүрэм, хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтын дүрэм, одоо мөрдөгдөж байгаа бусад холбогдох дүрэм, стандартын дагуу кабель бүр нь гүйцлээс хамарсан удаан хугацаагаар байх болохуйц ачаалалтай байна.

5.1.12. 10 кв /10 кв хүчтэй оросд хүртэл хүчдэлийн кабель шугамуудын агаарын хед 5 жилийн хугацаанд их ачаалалын цагуудад /хүснэгт № 2 / заалдсан хэмжээнд хэт ачаалалтай байх болно.

Хүснэгт № 2

	Удаан хугацааны хэт ачааллын коэффициент		
	1	3	6
Хөрсөнд	1,5/1,35	1,35/1,25	1,25/1,2
Агаарт	1,35/1,3	1,25	1,25
Хоолойд /газар доор	1,3/1,2	1,2/1,15	1,15/1,1

Т а й л б а р : -Хүртвэрт урьтчилсан ачааллын коэффициент -0,8 жуваарьт -0,8 -15-аас дээш жил ашигласан кабель шугамын хэт ачааллыг 10 % бууруулж тооцно.

5.1.13. Хувьсах гүйдлийн 6-10 кв, тогтмол гүйдлийн 1000 хүртэл вольтын хүчдэлтэй кабель шугамд тугалган болон эпексид холбогч муштыг хэрэглэнэ. Мөн түүнчлэн батлагдсан угсралтын технологийн бол оор төрлийн мушт хэрэглэхийг зөвшөөрнө. Ус залуулах байгууламд, худаг, ба шивнгуудын доторхи 6-10 кв хүчдэлтэй кабелийн шугамын шөрмөн муштыг эхний зөвлөлд сэлж байна. Газар дор байгаа муштуудыг заавар хийх үедээ сэлж болно.

5.1.14. Хүчний кабелийг бардгын дотор оруулах, хааят, ханг дамжуулан гаргахдаа цахилгаан дамжуулагчид холбогч ажиллана.

5.1.15. Кабелийн хуягны тугалган эсвэл хөнгөн цагаан бүрээс үзүүрийн ган зоронгийн их бие, бэхлэгчнүүд нь хоорондоо цахилгааны холбосгоор холбогдсон байх шаардлагатай. Харин цахилгаан татах дэд стангуудад үүрээс гадна газардуулгын битүү хэлхээгээр холбогдоно.

5.1.16. Кабелийн хуягны шугамын эсвэл хөнгөн цагаан бүрээс нь гэмтэж цав гарсан байх болохгүй. Хэлбэрч муштыг угсрах үед эалгах гэж байгаа кабелийн хуяг, бүрээснүүд нь цахилгаан холбосгоотой байх шаардлагатай.

5.1.17. Кабелийн үзүүрийн битүүмэллэгчнүүд кабель суулгасан газрын үзэл болох бүх хэсэгт тэмдэглэгээ хийж хаяг зүүсэн байна. Тэмдэглэгээг зохих зааврын дагуу хийнэ. Тогтмол гүйдлийн хэлхээний гүйдэл дамжуулагч болох сэлгэн эалгах төхөөрөмжүүдийн зэрэг потенциалтай кабелийг хөх өнгөөр ялгана. Хувьсах гүйдлийн кабелийн тугалгаа ба сэлгэн эалгах төхөөрөмжүүдийг үзүүрийн битүүмэллэгчнүүдийн А фазыг шар, В фазыг ногоон, С фазыг улаан өнгөөр тус тус ялгаж бууда.

5.1.18. Тогтмол гүйдлийн төхөөрөмж шугам нь тус тусдаа эсвэл зэрэгцээ ажиллах чадвартай байх шаардлагатай. Төхөөрөмж ямар ч системийн үед кабель нь богино холболт, зэврэлтээс найдвартай хамгаалсан хамгаалалтын төхөөрөмжүүдээр хангагдсан байна. Газраас тусгаарлагдсан туйлуудтай цахилгаан хангаалалтын системийг газартай харьцангуйгаар зөрөл, зөрөл потенциал хэлхээүүдийн тусгаарлагчийг автоматаар хянах хэрэгжлийг урьдчилан чавьсан байх шаардлагатай.

5.1.19. Троллеibusнуудын хөдөлгөөний нитралаас хамааруудан контактын сүлжээний цахилгаан хангамжийн ердийн ба аваарын горимыг тодорхой схемтэй байна. Цахилгаан хангамжийн ердийн горимын схемийг зөвхөн засвар хийх эвэл онцгой нөхцөлд өөрчлөхийг зөвшөөрнө. Тэжээлийн аль нэг кабелийг тасалж үеэлт засвар хийх үед троллейбусны хөдөлгөөнийг зогсоохгүй байхаар тооцож хэсэгчилсэн контактын сүлжээ ба тэжээлийн схемийг боловсруулан хийнэ.

5.1.2Г. Тогтмол гүйдлийн тэжээлийн шугамын хяналтын илүүдлийг кабелийн байдлыг тодорхойлох дохмолой болгон ашиглаж болно.

5.2. Кабелийн шугамын техникийн үйлчилгээ:

5.2.1. Хэрэглэгчийн цахилгаан тээвэр төхөөрөмжийн ашиглалтын болон хэрэглэгчид цахилгаан тээвэр төхөөрөмжийн ажиллагааг техникийн дүрмийн дагуу кабелийн сүлжээний төхөөрөмжүүд кабелиудад техникийн үйлчилгээ, засварыг жилд нэгээс доошгүй удаа хийнэ.

5.2.2. Кабелийг механик гажуудлаас хамгаалахын тулд кабелийн шугам бүрийг хяналтанд авсан байх шаардлагатай.

5.2.3. Мердегдөл байгаа дүрэм зааврыг дагуу өндөр хүчдэлийн кабелиудад жилд нэгээс доошгүй туршилта хийх ёстой. I кв хүртэл хүчдэлтэй кабелиудыг жилд 2 удаа 6-10 кв-ын хүчдэлтэй кабелиудыг жилд I-ээс доошгүй удаа тус тус туршина.

5.2.4. 6-10 кв-ын хүчдэлтэй хувьсах гүйдлийн кабелийн турших хүчдэлийн хэмжээ шугамын хүчдэлийн номинал хэмжээнээс 5 дахин илүү, харин кабелийн ашиглалтаанд авах туршилтын үед 6 дахин илүү байна. 1000 В хүртэл хүчдэлтэй тогтмол гүйдлийн кабелийг турших хүчдэлийн хэмжээ 5 кв байна. Туршилтын хугацаа 5 минут байна. Талбар: Удаан хугацаагаар ашиглагдах зорлуулалттай тогтмол гүйдлийн кабелийн байдлаас хамаарч туршилтын хүчдэлийн хэмжээг багасгаж болно. Их засвар хийгдсэн серет потенциалтай кабелийг 1000-250 В хүчдэлтэй мегаомметрээр туршиж болно.

5.2.5. 1000 В дээшгүй хүчдэлтэй тогтмол гүйдлийн кабелийн хяналтын жижиг тургаарлагчийг газартай харьцангуйгаар гүйдэл

дамжуулагч ялийн хамт 5 кв-ын хүчдэлээр туршина.

5.2.6. Өрлийн улиралд агаарын температур 5°C -доош байх нөхцөлд кабелийг шуудуунд сунгахээс өмнө оруулгыг урьдчилан халаасан байх ёстой.

6.Замын дохиолох хэрэгслүүд:

6.1. Ерөнхий шаардлага

6.1.1. Замын дохиолох хэрэгслүүд нь тээврийн хэрэгсэл болон явган зорчигчдын хөдөлгөөнийг зохицуулахаас гадна зорчигч тээвэрлэлтийн шилд аюулгүй ажиллагааг хангахад нөлөөлнө.

6.1.2. Замын дохиолох хэрэгслүүд нь автомат болон ердийн /гар/ удирдлагатай гэрлэн дохиолол, замын тэмдэг заалтуудаас бүрдэнэ.

6.1.3. Дор дурьдсан гэрлэн дохиололын гэрлүүд, тэмдэг заалтууд хэрэглэгдэнэ. Үүнд:

-Анивчсан шар гэрлийн нэг секцтэй гэрлэн дохиолол

-Нөгөөн улаан гэрлүүдтэй хоёр секцтэй гэрлэн дохиололууд /зөвхөн троллеibusны замсочид хамаарах дохиололд хэрэглэнэ/

-Улаан, шар, нөгөөн гэрэлтэй гурван секцлийн болон нэмэгдэл секцтэй гэрлэн дохиолууд

-Цагаан-шаргал өнгийн, өндөр хэлбэрийн гэрлэн дохиолол

-Тоо, үсэг болон тэдгээрийн хавсарсан бичлэгтэй замын тэмдэг заалтууд

6.1.4. Дохиоллын хэрэгслийг тусгай суурь, тулгуур, башин барилга, контактн сүлжээний хөндлөн бэхлэгч дээр болон зогсоолын сүүдрэвч зэрэгт дохиололын төхөөрөмжүүдийг бэхлэхдээ цахилгаан шугамын хийц, байгууламжийн бат бэх байдал, цахилгаан тусгаарлалтын шаардлагыг зөрчин болохгүй.

6.1.5. Тулгуур, башин барилга, тусгай суурь дээр байрлуулсан дохиоллын хэрэгслийн тэмдэг заалтууд нь газрын гадаргаас 2,5 м-ээс доошгүй, тээврийн хэрэгсэл ба явган зорчигчдын хөдөлгөөнд саад болохгүйгээр хийсэн байвал зохино.

6.1.6. Замын дохиоллын хэрэгслийн цахилгаан төхөөрөмж газардуулагдсан хэсэгт давхар тусгаарлагчтай байх ёстой. Газраас дээш 2,5 м-ээс өндөргүй байрлуулсан төмөр шүүтээ, хамгаалалт гэр болон дохионы хэрэгслийн удирдах хэсэгт газардуулга хийгдсэн байна.

6.1.7. Цахилгаан дохиоллын хэрэгслийн төхөөрөмж түүний угсралтын амлал нь: ажлуугүй ажиллагааны болон цахилгаан тоног төхөөрөмж, байгууламжийн ашиглалтын дүрмийн шаардлагад тохирсон байвал зохно.

6.2. Гэрлэн дохиоллын автомат удирдлага:

6.2.1. Гэрлэн дохиоллын удирдлага нь троллейбус явж өнгөрөхөд, хөдөөчийн үндлээс хамгаархуугаар автоматаар гүйцэтгэгдэнэ.

6.2.2. Гэрлэн дохиоллын оролт, гараагийн агаарын контактын хоорондох зай нь тухайн хязгаарлагдсан замын хэсэгт троллейбус тодорхой өгөгдсөн хурдтай явж өнгөрөх кутаргаагаар хэмийгдэнэ.

6.2.3. Контактны сүлжээний хэсэгчилсэн тусгаарлагччууд болон троллейбусны контактын сүлжээ огтлолцсон хэсэгт гэрлэн дохиоллын хэрэгсэл хэлбөхтэй хориглоно. Агаарын контакт байрлуулах болон түүний тэгээлийн замыг троллейбусны контактын сүлжээнд хэлбөхдөө хэсэгчилсэн тусгаарлагчийн зөвхөн нэг талд нь холбоно.

6.3. Гэрлэн дохиоллын алсын удирдлага:

6.3.1. Тусгай төхөөрөмжлөгдсөн байрнаас гэрлэн дохиоллыг алсаас удирдана.

6.3.2. Гэрлэн дохиоллын удирдлагын байрны үндлэх гэрлэн дохиоллууд аль болох сайн харагдах газарт байрлуулна.

6.3.3. Удирдлагын байрны байршилт дохиоллын хэрэгсэлийг ашиглуулж байгаа хүний ажлуугүй байдлыг хамгаан, тээврийн хэрэгсэлд болон явган зорчигчийн хөдөлгөөнд ооод болохгүй байхаар байрлуулна зохно.

6.3.4. Дохиоллын удирдлагын гүйцэт нь гэрлэн дохионы ажиллагааг давтан харуулж чадах хяналтын дохиоллын самбаргаар тоноглогдсон байх ёстой.

6.3.5. Хяналтын замбар гэмтэлтэй байх үед удирдлагын мультитиг ажиллуулахыг хэргэлэнэ.

6.3.6. Троллейбусны хөдөлгөөний нэг зангылгаан дээр хэд хэдэн гэрэл дохиололт бээрлүүлсэн тохиролдолд тэдгээрийн холболтын схем нь троллейбусыг еед еедөөс нь явуулахгүй байх автомат хяналтын системээр тоноглогдсон байна.

6.3.7. Троллейбусны зам нь төмөр замын нэг түвшинд ортолцох үе дэх гарамны дохиолол нь БНМАУ-ын Сайд, нарчин Зөвлөлийн дэргэдэх төмөр замын хэрэг эрхлэх газраас батлагдсан гарамыг төхөөрөмжлөх үйлчлэх зааврын дагуу тоноглож үйлчилгээт зохион байгуулах хэрэгтэй.

6.4. Гэрлэх дохиоллын хэрэгслийн техникийн үйлчилгээ, арчилт:

6.4.1. Дохиоллын хэрэгслэлүүдэд удирдах дээд байгууллага болон троллейбусны комбинатаас баталсан үечлэл, техникийн тодорхоллолт, тусгай зааварчлагын дагуу техникийн үйлчилгээ засвар хийгдэнэ.

6.4.2. Дохиололын хэрэгслийн ашиглалттай холбоогүй зохих албаны зөвлөсөөрлгүй гадны хүмүүс дохиоллын системд ямар нэгэн ажил үйлчилгээ хийхийг хэргэлэнэ.

7. Холбоо

7.1. Ерөнхий шаардлага:

7.1.1. Троллейбусны комбинатад үндвэрийн болон технологийн холбоо, /хотын нийтийн хэрэгцээний холбооноос гадна/, захиргаа-албаны диспетчерийн холбоог хэрэглэнэ.

7.1.2. Захиргаа-албаны дотоод холбоо нь байгууллагын үндвэрлэлийн үйл ажиллагааны талвар мэдээлэл солилцох ба байгууллагын бүх хэрэглэгчдийн /депо, троллейбус, засварын төхүүд г.м/ холбоо хөрөндийн харилцаат хэлбэрд зориулагдана. Захиргаа-албаны холбооны техник хэрэгслийн төрөлд байгууллагын буюу хотын зориулалттай автомат ба ердийн телефон станц хэрэглэгдэнэ.

7.1.3. Диспетчерийн холбоо нь үйлдвэрлэлийн асуудал, хөдөлгөөний зохион байгуулалт, гэмтэл засварлах, ашиглалтын талаар шуурхай удирдлага, заалт өгөхөд зориулагдсан техник хэрэгслэл юм.

Диспетчерийн холбоо нь шуурхай удирдлагаас/ диспетчер, оператор бусад/ еерийн байгууллагын хэрэглэгчид, түүний салбаруудын хоорондох шууд телефон харилцааг хангана. Диспетчерийн шуурхай холбооны техник хэрэгслэлд симплексийн, дуплексийн өсгөгчтэй коммутаторыг хэрэглэнэ.

7.1.4. Технологийн холбоонд шууд дамжуулах сувгийг ашиглана. Үүнд: Троллейбусны цахилгаан хангамжийн системийн хувьсгах, татах дэд станцын алсын удирдлагад троллейбусны ашиглалт, үйлдвэрлэлийн телетайг холбооны хэрэгслүүд, автомат удирдлагын системийн мэдээллийн хэрэгслэлд тус тус ашиглана.

7.1.5. Үйлдвэрлэлийн ба технологийн холбооны сувагт троллейбусны еерийн телефон холбооны буюу хотын албан байгууллагуудын телефоны сүлжээнд холбоосон утсан холбоонуудыг ашиглана.

7.2. Троллейбусны байгууллагын системд

үйлдвэрлэлийн телефон ба радио холбоот хэрэглэх:

7.2.1. Троллейбусны бүх эцсийн буудлууд нь хөдөлгөөнийг удирдах хотын төв диспетчертэй хотын буюу захиргааны албаны мөн шуурхай диспетчерийн телефоны сувгаар холбогдсон байх шаардлагатай. Телефон холбоо нь ганц сувагтай байх нөхцөлд хоёр дахь /неэцгийн/ сувгийн төрөлд хэт богино долгион радио холбоот ашиглаж болно.

7.2.2. Троллейбусны хөдөлгөөнийг зохицуулах засварын пэгүүд нь еер хоорондоо буюу диспетчерийн үйлдвэрлэлийн холбоотой байх шаардлагатай.

7.2.3. Байнгын шалган бүртгэх цэг нь барилдаасаа хамааран диспетчертэй шуурхай диспетчерийн холбооны сувгаар холбогдох бөгөөд гэрлийн км-уу дуут дохионы хэрэгслээр тоноглогдсон байна.

7.2.4. Траллейбусны зорчих чиглэлийн 2-2,5 км зам тутамд диспетчертэй үйлдвэрлэлийн холбоогоор харьцах боломжтой байхаар тоноглох хэрэгтэй.

7.2.5. Хөдөлгөөний алба, хөдлөх бүрэлдэхүүний хэсэг, цахилгаан хангамжийн албаны ашиглалтын ба зааврын бригад, техникийн түргэн тусламж зэрэг салбар албууд нь диспетчертэйгээ шуурхай диспетчери н хотын буюу захиргаа албаны холбооны сузгаар холбогдсон байх ёстой.

7.2.6. Удирдах албаны тусгай автомашин, цахилгаан хангамж, ашиглалтын ба гэмтэл засвар, техникийн түргэн тусламжийн автомашинууд диспетчерүүдтэйгээ шуурхай холбоотой байхын тулд хэт богино долгионы радио станцаар заавал хангагдсан байна.

7.3. Радио, телефон холбооны техникийн үйлчилгээ эрчлэлт:

7.3.1. Радио, телефон холбооны техник хэрэгсэлүүдэд удирдах дээд байгууллага буюу траллейбусны комбинатаас баталсан үечлэл, техникийн тодорхойлолт, тусгай зааварчлагын дагуу техникийн үйлчилгээ засвар хийгдэнэ.

7.3.2. Хэт богино долгионы радио станцын ашиглалт, түүгээр радио мэдээлэл өслөлийнх журам нь БЭМАУ-ын Холбооны Яамнаас баталсан, траллейбус ашиглалтын систем дэх шуурхай диспетчерийн холбооны хэт богино долгионы радио станцуудыг ашиглалтын зааварчлагын дагуу гүйцэтгэх ёстой.

7.3.3. Телефон радио холбооны төхөөрөмжүүдийг тэдгээрийн ашиглалттай холбоогүй зохих албаны зөвшөөрөлгүй радио хүмүүсээр ямар нэгэн үйлчилгээ хийлгэхийг хориглоно.

8. Хөдөлгөөний зохих байгуулалт

8.1. Үндсэн шаардлагууд

8.1.1. Зорчигч урсгалын хэмжээ, чиглэлээс маршрутын схем зохино. Маршрутын схемийг батлах, эерчилж оруулахыг хотын

АДХ-ын Гүйцэтгэх Захиргаа шийдвэрлэнэ. Маршрутын схем, чиглэлд өөрчлөлт орсон тухай бүрт хуш амд урьдчилж мэдэгдэх ёстой.

8.1.2. Троллейбусны комбинатын бүх салбар, хэсгүүдийн ажлыг нэгтгэн зангидсан цугамын үйлчилгээний график нь троллейбусны хөдөлгөөнийг зохион байгуулах үндэс болно. Троллейбусны цугамын үйлчилгээний графикийг троллейбусны комбинатын дарга буюу түүний эрх олгосноор хөдөлгөөний албаны дарга батална.

8.1.3. Троллейбусны цугамын үйлчилгээний график нь хөдөлгөөнтэй холбоотой хотын захилгаан тээврийн бүх ажиллагчдын хувьд дагаж мөрдөх хууль байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байх ш кэрэгтэй.

Үүнд:

- хөдөлгөөний ажилгүй байдал
- маршрутанд эвэхүү дүрэм болон замын хөдөлгөөний дүрмийн дагуу зөвлөмөөрөгдсөн хурцаар явах боломжийг хангах
- Троллейбусны маршрутын хуш амлалд нэг нь өөр хоорондоо болон бусад төрлийн тээвэр, үйлдвэр, албан байгууллагуудын ажиллах хуваарьтай уялдуулан байх
- Хөдлөх бүрэлдэхүүнийг аль болох ашигтай ажиллуулах
- Техник эдийн засгийн төлөвлөгөөг үзүүлэлтийн биелүүлэх
- Жоносчийн ажлын төлөвлөсөн хуваарийг дагаж мөрдөх
- Хөдлөх бүрэлдэхүүний техникийн үйлчилгээний мөрдөгдөж байгаа системийг хэрэгжүүлэх
- Гудамж зам, уулзвар, эцсийн буудлууд, чиглэлүүдийн нэвтрүүлэн өнгөрүүлэх чадварын хэмжээнд хөдөлгөөний давтамжийг тооцсон байх

8.1.4. Хөдөлгөөний графикийг бүх чиглэл, троллейбус, засварын шалгах цэг болон эцсийн зогсоол бүрт тавигдсан байх шаардлагатай.

8.1.5. Троллейбусны зогсоос гарах, үйлдэх чиглэл, хяналтын цэгүүдээр дайрч өнгөрөх, буудлуудад зогсох, эцсийн буудлаас буцах, цөлсө ирэх, төлөгчийн үйлчилгээнд орох, зогсох мөн ээлж олгох, засварлага хийх, цаг мух цагууд нь үйлчилгээний графикт нарийн заагтарай байгаа тусгай маршрутад болон түүний хэсгүүдэд шаардлагатай тохиолдолд богино рейс хийлгэх, өөр чиглэлээс троллейбус авах зэргээр хөдөл-

гөөний графикт оорчлөлт оруулах үйлчилгээр зохион байгуулж болно.

8.1.6. Зорчигч урсгалд өөрчлөлт орох цаг агаарын нөхцөлөөс хамаарч жилийн 4 улирал болон ажил, амралтын өдрөөр хөдөлгөөний графикийг ялгавартай үйлнэ. Газар орон нутгийн цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан троллейбусны комбинатын тушаалаар троллейбусны үйлчилгээнд улирлын график хэрэглэх хугацааг тогтооно.

8.1.7. Троллейбусны ажлын наряд нь зорчигч тээврийн үйлчилгээний график зохиох үндэс болох бөгөөд төлөвлөлтийн анхан шатны тооцооны ажил юм. Троллейбусны контактын сүлжээний зангилгаануудын нэвтрэн өнгөрүүлэх чадвар гүйцлийн хронометраж хийж тогтоосон хугацаа, хүн урсгалын судалгааны материалыг үндэслэн нарядыг боловсруулна.

8.1.8. Троллейбусны нарядыг тодорхойлохдоо:

-Дого-маршрутын хувьд ажиллана;

-Маршрутад ажлын троллейбусны тос;

-Троллейбусны төрөл бүрэлдэхүүн;

-Троллейбусны зөвхөн сэлэлт;

-Тээврийн ажлын хэмжээ, машин-цаг, машин-км, ашиглалтын дундаж хурд.

-Маршрут бүрийн оргил ачааллын хоорондох хугацаа ба өглөө оройн оргил ачааллын үе дэх троллейбус хоорондын хугацааны давтамжийг тогтооно.

8.1.9. Троллейбусны нарядыг ажлын ба амралтын өдрийг харгалзан тогтоож улиралд нэгээс доошгүй удаа хянана.

8.1.10. Хөдөлгөөний алба троллейбусны ажиллам нарядыг боловсруулж дотоо, цахилгаан хангамжийн алба, төлөвлөгөө эдийн засгийн хэлтэстэй зөвшилцөж троллейбусны комбинатын даргаар батлуулна.

8.2. Шугамын барилга байгууламшид тавигдах

шаардлагууд:

8.2.1. Троллейбусны зогсолтын байршилчлэл тогтоож тоноглохдоо хөдөлгөөний ажилгүй байдалд хавтах, нэвтрүүлэх чадвар,

зорчин явагчдын тав тухтай байдлыг харгалзахаас гадна, троллейбусны шугамд тавигдах техникийн шаардлага, хотын нийтийн хэрэгцээний тээврийн зогсоолыг байрлуулах, тоноглох хэмжээ техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэнэ. Зогсоолуудын хоорондын зай нь 350-600 м байна.

8.2.2. Зогсоолыг зорчигч урсгалаас хамааран байнгын ба түр гэж ангилна. Троллейбусны түр зогсоол зөвхөн зорчигчдын хүсэлтийн дагуу шаардлагатай хөд троллейбус зогсоно.

8.2.3. Троллейбусны комбинатын шийдвэрээр хөдөлгөөний ажилгүй байдлыг хангах зорилгоор техникийн зогсоолыг зохион байгуулах бөгөөд нйм зогсоолд зорчигчид бууж суухыг хориглоно.

8.2.4. Эцсийн буудал нь гуурхай удирдлагаар хангах, гүйцэтгэсэн ажлы бүртгэлийг хөдөлх үүрэгтэйгээр удирдлага, зөвхөн хөдөлгөөнд хяналт тавих үүрэгтэйгээр техникийн гэж 2 ангилагдана.

8.2.5. Чиглэл бүрт нэгээс доошгүй, эцсийн буудал байна. Эцсийн буудлын үйлчлэх хүрээг троллейбусны комбинатын шийдвэрээр батлана. Бүтэн рэйсийн үргэлжлэх хугацаа 1,5 цагаас илүү байвал маршрутын нөгөө эцэст ариун цэврийн өрөө бүхий байр байгуулна.

8.2.6. Эцсийн буудлуудад троллейбус эргэх, гүйцэж түрүүлэх, удаан хугацаагаар зогсох, жижиг засвар хийхэд зориулагдсан контактын сүлжээ бүхий хатуу хучилттай талбай, жолооч үйлчлэгчдийг халуун хоол ундаар үйлчлэх, түр амрах, ариун цэвэр ажлын өрөөтэй байртай байна.

8.2.7. Эцсийн буудал, станцын барилга нь нэг загварын зураг төслөөр баригдсан байна.

8.2.8. Эргэх, гүйцэж түрүүлэх, удаан хугацаагаар зогсох жижиг засвар зориулсан талбай, эцсийн буудлын зорчигч суулгаж буулгах талбай нь нөхөн цагт заавал горелтүүлэгдсэн байна.

8.2.9. Уцардлагын болон техникийн эцсийн зогсоол, станц хяналтын дундын цэгүүдийн байрыг харьж хамгаалах ажлыг уламжлалт хөдөлгөөний алба хариуцах ба харин урсгал болон төлөвлөгөөт засварыг троллейбусны комбинатын даргын шийдвэрээр хэлсэгдох албадад хариуцуулна. Троллейбус удаан хугацаагаар зогсох, эргэх зоржуулалттай талбай, зөрчигчдын буух, суух зогсоолын арчлалт, засварыг хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны шийдвэрээр хэлсэгдох газар хариудан гүйцэтгэнэ.

Төмөр зам хөндлөн гарах уулзвар

8.2.10. Троллейбусны шугам барихад төмөр замын гол хэсэг, түүний салбар замыг хөндлөн гарах бичиг бүр бүр тусгайнд барьж байгуулах зарчмыг баримтлана. Троллейбусны шугам үйлдвэрийн газруудын салбар, цахилгааншааргүй төмөр замуудыг хөндлөн гарах бол зохих техник эдийн засгийн үндэслэлийн дагуу нэг түвшинд барьж болно. Гэхдээ хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ төсөлд тусгах ёстой. Өүнөө өхнө харилцан бие биеийг харах нөхцөлийг хангахын дээр дохтолол, хаалтын төхөөрөмжөөр тоногдоно. Хөндлөн огтлолцооллын өнцөг нь 45 градусаас багатай байвал зохино.

8.2.11. Троллейбусны шугам, төмөр замын огтлолцол нь СН и II болон /гарцын байгуулалт болон түүний үйлчилгээний шаардлага/ энэхүү дүрмийн дагуу троллейбусны комбинатаас төмөр зам ажилма-тын байгууллагатай хамтран боловсруулж, хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргаанаас баталсан тусгай зааврын шаардлагыг хангасан байх ёстой. Энэхүү зааварт төмөр зам, троллейбусны шугам огтлолцсон уулзварыг ашиглах хугацаа журам, харилцан дохиомол өгөх, гэрэм-түклээ хамгаалалт, хамгаалах төхөөрөмж хэрэгсэлд тавигдах шаард-лагыг тодорхойлсон байна.

8.2.12. Троллейбусны шугам, төмөр замтай огтлолцох уулзварын өөр өөр түвшинд барихдаа төмөр зам дээгүүр авто түүр байгуулна. Замны хучлагын түвшингээс төмөр замын түүрний доод ирмэг хүрт-лэх өндөр 4,5 м-ээс багатай байна.

8.2.13. Уулзвар нь орчны харагдах нөхцөл сайтай троллейбус уулзварын эмне түргэн зогсох боломжоосгоор хангагдсан байна.

Зам:

8.2.14. Троллейбусны зам нь асфальт бетонон, бетэн чулуун хучимттай, 60 хувьнаас илүүгүй наламттай байна.

Троллейбусны замын өргөн нь хөдөлгөөний 2 тални урсгалтай бол 15 м-ээс доошгүй, нэг урсгалтай 7,5 м-ээс доошгүй байна. Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны зөвшөөрлөөр өргөтгөл шинэчлэлт, засварын ажил хийх хөд 6,8 м өргөнтэй зам дээр 2 урсгалтай хөдөлгөөнийг түр зохмон байгуулж болно.

8.2.16. Өвлийн улиралд зөрчилгөөл суух талбай, гудамж, ялангуяа зам-н огсох уруудах хэвтэй хэсгийн цас мөсийг байнга цэвэрлэх, зам цугуй хоёрын барьцалын коэффициентийг дээшлүүлэх зорилгоор алс болон бусад зүйлийг цацаж байна. Зам нь өвгөр, товгор, нух хөндөр үхсөөгүй тагш тадаргуутай байх шаардлагатай.

8.2.17. Зам, засах, мөс цас цэвэрлэх, алс цацах ажлыг гэрхлэх байгууллагуур хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны шийдвэрээр томшино. Замын байдалд хяналт тавих ажлыг хөдөлгөөний алба харлуцна.

8.2.18. Хэрэв зам маршрутад үргэлжилсэн буюу хэсэгчилсэн эвдрэл үүсч, тэр нь хөдөлгөөний аюулгүй байдал, техникт хортой нөлөөлбөл мөн энэ дүрмийн шаардлагыг хангахгүй байвал төв диспетчер нь Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, троллейбусны комбинагад яаралтай мэдэгдэж троллейбусны үйлчилгээг түр хаах эрхтэй болно.

8.2.19. Троллейбус явцат зам дээр ажил гүйцэтгэхдээ ажил эхлэх үед дуусах хугацааг троллейбусны комбинагын хөдөлгөөний албатай заавал тохиромжсон байна. Троллейбусны цугамын дагуух замын дөрөлтүүлэг, барилгын норж ба дүрэм /СНИП/ -ийн шаардлагыг хангасна ба на.

8.3. Троллейбусыг депогоос шугамд гаргах, троллейбусыг хүлээн авах

8.3.1. Троллейбусыг депогоос хуваарийн дагуу гаргана. Хуваарьт зориогүй троллейбусыг зөвхөн төв диспетчерийн зөвшөөрлөөр гаргана.

8.3.2. Засвар, техникийн үйлчилгээний бүртгэлийн дэвтэрт жолоочийн захиалгаар бичигдсэн гэмтлийг арилгаагүй, троллейбус ажилд бэлэн байгаа тухай мастерийн тэмдэглэлгүй троллейбусыг депогоос гаргахыг хориглоно. Гэмтэл давтаж гарсан үед түүнийг арилгаж засварласныг депогийн ахлах инженер шалгаж батлана. Хэрэв ахлах инженер байхгүй тохиолдолд ахлах мастер эсвэл троллейбусны комбинатын депогийн даргын шийдвэрээр томилсон хүн шалгана.

8.3.3. Троллейбус бүрийг тодорхой маршрут, бригадэд хуваарилан харууцуулж өгнө.

8.3.4. Депогоос гарч байгаа троллейбусыг ажил үүргийн дагуу жолооч хүлээж авна. Троллейбус техникийн хувьд бүрэн бүтэн шугамд ажиллаж болох тухай мастер, шугамд гаралтыг зохион байгуулдаг диспетчерийн гарын үсэгтэй замын хуудас нь троллейбусны депогоос гаргах шугамд ажиллуулж болох эрхийн баримт бичиг болно. Замын хуудсанд гарын үсэг зурах үндэслэл нь троллейбусны засвар, техникийн үйлчилгээний бүртгэлийн дэвтэрт бичигдсэн техникийн бүрэн бүтэн байдлын тухай тэмдэглэл болж өгнө.

8.3.5. Жолооч нь депогоос гарах үедээ троллейбусны тормоз, жолооны удирдлага, генераторын ажиллагааг шалгаж, гадна ямар нэг дуу чимээ байхгүйг магадлах ёстой. Гэмтэл байгааг илрүүлсэн үед жолооч троллейбусыг зогсоож энэ тухай гаралт харуусан хүнд эсвэл хөдөлгөөний албаны шугамын ажилтанд мэдэгдэж тэдний заавраар ажиллах үүрэгтэй.

Тайлбар: 1. Хөдөлгөөний ажлуугүй байдлыг хангах үүрэгтэй аялагч, зангилгээний гэмтлийг зорчижгүйгээр троллейбусыг комбинатын тушаалаар баталсан замд шалгаж болно.

2. Шугамд орох, шугамаас буух үедээ явах чиглэлийн дагуу зогсоол бүрт заавал зогсож үйлчлэх үүрэгтэй.

8.3.6. Троллейбусыг эцсийн зогсоол дээр ирээд маршру- тандаа гарч бүтэн рейс хийсэн тохиолдолд депогоос гарч шугамд орсонд тооцно.

8.3.7. Шугамд гарсан хөдлөх бүрэлдэхүүн хөдөлгөөний албаны цуурхай удирдлагад шилжинэ. Шугамд байгаа хөдлөх бүрэлдэхүүний бүрэн бүтэн байдлыг жолооч, шугамын засварчин харуулна.

8.4. Троллейбусыг кондукторгүй, кассгүйгээр үйлчилгээнд ажиллуулах :

8.4.1. Кондукторгүй үйлчилгээтэй үед троллейбусны заланд хагас автомат, эсвэл нумгуулагч касс, компостер, тус бүр 2-оос доошгүй, кассгүй үйлчилгээтэй үед 3-7 компостер тус тус байрдуулсан байх хэрэгтэй. Касс нь орлогын бүрэн бүтэн байдлыг хангах, компостер нь хяналтын билет /талон/-ыг цоолох үүрэгтэй.

8.4.2. Кондукторгүй ба кассгүй үйлчилгээтэй үед троллей- бус ажиллуулах журмыг Тээврийн яам, Хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргаа баталж мөрдүүлнэ.

8.5. Хөдөлгөөнийг удирдах

8.5.1. Хөдөлгөөний жигд ажиллагаа, аюулгүй байдлыг хан- гахад хяналт тавих удирдахын тулд троллейбусны маршрутын сүлжээг хэлтэс тасгийн шалтгагчийн хэсэг, эцсийн зогсоолын хэсэг гэж ангилна. Хэсэг, шалгах хэсэг, эцсийн зогсоолын хэсгийн тоо, ажлын хүрээ заагийг хөдөлгөөний алба боловсруулж, троллейбусны комбинатын дарга батлана.

8.5.2. Хэсгийг хэсгийн дарга, эцсийн зогсоолыг диспетчер, шалгах хэсгийг хөдөлгөөний байцаагч, маршрутыг маршрутны дарга, троллейбусыг жолооч нь тус тус хариуцаж удирдана. Тэд нарт ажил үүргийн заавар, төлний-захирамжийн акт замын хөдөл- гөөний дүрэм болох энэ журмын хүрээнд хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө хариуцаж ажиллана.

8.5.3. Техник-захирамжийн актыг эцсийн зогсоол бүрт гаргана.

8.5.4. Техник захирамжийн актаар тогтоогдсон хөдөлгөөн, байршуулалт болон маневрийн ажлыг гүйцэтгэх журмыг троллейбусны комбинатын бүх албадын ажилчид заавал мөрдөж байх хэрэгтэй.

8.5.5. Шугамын троллейбус бүрийн хөдөлгөөнийг зохицуулж шуурхай удирдлагаар хангах үүргийг зөвхөн төвийн диспетчер гүйцэтгэнэ. Шугамд ажиллах байгаа троллейбусны үйлчилгээтэй холбоотой ажилтан бүр төв диспетчерийн удирдлагын шийдвэрийг үг дуугүй бислүүлэх ёстой. Төв диспетчерт мэдэгдэхгүйгээр троллейбусны хөдөлгөөний талаар газар дээр нь шуурхай шийдвэр өгөхийг хориглоно.

8.5.6. Төвийн диспетчерийн үүрэг, шийдвэр, шугамд гарсан осол зөрчил болон графикийн өөрчлөлтийн тухай хяналтын ба эцсийн буудлын диспетчерээс үнэн зөв мэдээллийг шуурхай дамжуулах, хүлээн авч, хөдөлгөөний удирдлагыг зохион байгуулна.

8.5.7. Троллейбусны хөдөлгөөний хоорондын интервал 3 минутаас дээш байх үед ± 2 минут, интервал 3 минутаас түүгүй байх үед ± 1 минутын хэлбэлзэлтэй явж, графикт зааргасан хугацаа баримтлагдаж байвал жигд ажиллагааг хангаж байна гэж үзнэ.

8.5.8. Троллейбусны үйлчилгээнд дараах швартлага хангагдсан байх ёстой.

- Шугамд ажиллах троллейбус тоо ёсоор

- Техникийн ямар нэгэн гэмтэлгүй гарсан байх

- Контактны сүлжээ ба кабелийн холбох шугам шугамын дагуух замын байдал гэмтэлгүй бүрэн бүтэн байх.

- Холбооны төхөөрөмж нэхимгаан татах дэд станцын ажиллагаа тогтвортой хэвийн байх

- Хөдөлгөөний албаны ажилтнууд, жолооч нар боловч троллейбусны хөдөлгөөнтэй холбоотой бусад албадын хүмүүс ажил үүргээ нарийн чанд биелүүлэх.

8.5.9. Троллейбусыг эцсийн буудлаас диспетчерийн хяналтаар шугамд гаргана.

8.5.10. Маршрутын аль н хэсэгт хөдөлгөөний саатал гарсан үед хөдөлгөөний зохицуулагч нь хамгийн урт маршруттай шугамд троллейбусны хөдөлгөөнийг хангуулах ба нийт маршрутын дагуу хөдөлгөөнийг ургэлжлүүлэх арга хэмжээ яаралтай авна. Маршрутын хөдөлгөөнийг ургэлжлүүлэх үед зорчигчид олон бутларсан буудлуудаас эхлэн үйлчилгээг зохмон байгуулах нь зүйтэй.

8.5.11. Маршрутын ямар нэгэн хэсэгт хөдөлгөөн хоригдсон үед тойрох хөдөлгөөн хийх схемийн дагуу хөдөлгөөний чиглэлийг хөдөлгөөний албаны шугамын ажлыннууд өөрчилж хөдөлгөөнийг өхлүүлэх шийдвэрийг өгч энэ тухайгаа төвийн диспетчерт яаралтай мэдэгдэх хэрэгтэй. Хөдөлгөөний чиглэлийг өөрчилсөн тухай шийдвэр нь: замын хуудсанд бүхэлдсэн байвал зохино. Төвийн болон маршрутын диспетчерийн утсаар өгөгдсөн аман шийдвэрийг энсийн буудалд ирэхэд нь диспетчер замын хуудсанд бичих хэрэгтэй.

8.5.12. Троллейбусны үйлчилгээг графикаар ургэлжлүүлэхийн тулд хөдөлгөөнийг зохицуулагч нь дараах эрхийг эдлэнэ.

- Троллейбусыг уртасгасан ба богиносгосон рейсэнд явуулах
- Хөдөлгөөнийг өөрчилсөн чиглэлд троллейбусыг явуулах
- Эцсийн буудлуудад зогсох хугацааг багасгах замаар эргэлтийн рейсийн хураацааг богиносгох
- Эцсийн буудлаас явуулах троллейбусуудын хоорондын интервалын хугацааг өөрчлөх
- Бэлтгэл троллейбусыг ашиглах болон бусад маршрутаас троллейбус авах
- Шугамд гарах троллейбусны хуваарийг өөрчлөх

8.5.13. Дас, бороо, манантай, зам хальтиргаатай болон цаг агаарын хундарсан нөхцөлөөс шалтгаалж хөдөлгөөний өгөгдсөн график биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд төвийн диспетчерийн шийдвэрээр хөдөлгөөнийг тусгай дэглэмд оруулна. Графикийг өөрчилно. Рейсийн эргэлтийн хугацааг тогтоохгүйгээр явуулах буруу уртасгана.

Хөдөлгөөний тусгай дэглэмд оруулах хугацаа ба журмыг тухайн байдлаас хамааруулан өөдөрхийн хөдөлгөөний албаны дарга баталж өгнө.

8.5.14. Троллейбус зохих чиглэлдээ явж чадахгүй тохиолдол гаргах, хөдөлгөөн саатсаны дараа нэг чиглэлд олон троллейбус бөөгнөрөхөөс бусад тохиолдолд зорчигчидтэй троллейбусны хөдөлгөөний чиглэлийг оөрчлөхийг хориглоно.

8.6. Троллейбусны хөдөлгөөн

8.6.1. Жолооч тормозлох үедээ урд явсаа тээврийн хэрэгслийг илгээх тохиолдол гаргахгүй байхаар зайг хөдөлгөөний курдаас хамааруулан сонгож явна. Ар араасаа явж байгаа троллейбусны хоорондын зай 20 км/цагийн хурдтай үед 30 метр, 40 хувийн налуу зам ба их хурдтай явж байх үед 60 метрээс багагүй байна.

8.6.2. Урд зогсож байгаа троллейбус, автобусанд оёртох зай тэгш газар 3 м, өрсүүр уруу газар 5 метрээс багагүй байна. Тайлбар: Үзэгдэх орчин муу байгаа нөхцөлд болов гүйсэх акул гарах үед /дасан шуурга, хальтиргаа г.м/ дээрх зайнууд хоёр дахин их байх шаардлагатай.

8.6.3. Хөдөлгөөний хунд нөхцөлтэй хэсэгт Тээврийн яамны баталсан хөдөлгөөний хунд нөхцөлтэй маршрутад троллейбус ажиллуулах тухай үндсэн зааварт заасны дагуу троллейбусны хөдөлгөөнийг зохлон байгуулна.

8.6.4. Троллейбусны хяалгэг нээлттэй явахыг хориглоно.

8.6.5. Тусгай зориулалтын троллейбусыг төвийн диспетчерийн зөвшөөрлөөр зорчигч тээврийн троллейбусны хөдөлгөөнтэй шугамд ажиллуулах болно. Тусгай зориулалтын троллейбусны хөдөлгөөн, гүйцэтгэх ажлыг троллейбусны комбинатын даргын баталсан тусгай заавраар тодорхойлж өгнө.

8.6.6. Тусгай зориулалтын троллейбус нь шугамд ажиллаж байхдаа зорчигч тээврийн троллейбусны хөдөлгөөний бүх дүрэмд захирагдана.

8.6.7. Дено, сүслэн буудлуудад манёврын ажил гүйцэтгэх журмыг троллейбусны комбинат батлана.

8.7. Троллейбусыг жолоодох журам:

8.7.1. Шугамд ажиллаж байгаа жолооч, кондуктор нар оорсдийн ажил үүргийн заавар, хотын хөдөлгөөний ба цахилгаан тээврийн

ажуулгүй ажиллагааны дүрэм болон энэ дүрмийг баримтлан ажиллана.

8.7.2. Жолооч шугамд ажиллаж байхдаа дараах үүргийг биелүүлж байх ёстой: Тусгай хамгаалалт бүхий автомашиныг цуваа, тусгай дуут дохио ба анивчдаг гэрлээр тоногдсон автомашин, м. тоциклийн жолоочийн дохиогоор нэн даруй зогсож зам чөлөөлөн өнгөрүүлнэ.

- Хөдөлгөөний ажуулгүй байдлыг хангах
- Хөдөлгөөний хуваарийг хатуу биелүүлэх
- Хөдлөх бүрэлдэхүүн түүний бүрэн бүтэн байдлыг хангах
- Цахилгаан эрчим хүчийг хэмнэлттэй зарцуулах
- Зорчигчдод соёлч шуурхай үйлчлэх
- Зорчигч тээвэрлэмтийн төлөвлөгөөг биелүүлэх
- Ажуулгүй ажиллагааны дүрмийг биелүүлэх
- Кондукторгүй үйлчлэх үйлчилгээний зааврыг баримтлах

8.7.3. Жолооч троллейбусыг зогсоол дээр бүрэн зогсоогоод хаалгаа онгойлгосн буудлын нэрийг эз тана. Буудлаас хөдлөхтэй өмнө жолооч заавал "Анхааралтай байгаарай, хаалга хаалаа! Дараагийн буудал" ... гэж зарлана.

8.7.4. Жолооч нь зорчигчид бууж, сууж дууссан, хаалганууд хаагдсан, урд талд зам чөлөөтэй байгааг мэдсэний дараа хөдөлгөөнийг эхлэнэ.

8.7.5. Хөдөлгөөний үед жолоочийн анхаарал замын хөдөлгөөн, дохиолол зам, контактын сүлжээний байдалд төвлөрөх ёстой.

8.7.6. Троллейбусны хөдөлгөөний үед жолоочийн бүхээрт жолоочийн албан үүргийн зааварт зааснаас бусад хүн суухыг хориглоно.

8.7.7. Жолооч дараах нөхцөлд троллейбусыг заавал зогсооно.
Үүнд:

- Зогсоол бүр дээр
- Гэрэл, дохиолол зохицуулагчийн дохиогоор
- Цагдан сэргийлэхийн ажилтан, шугамын ажлыгчид, автотехникийн олон нийтийн байцаагчийн шаардлагаар
- Кондуктор, шалгагч, зорчигч болон хэн нэгэн хүн ажуулын дохио өгөх

Мөргөлдөх, дайрах аюул гарч болзошгүй хөд

-Троллейбусанд гэнэт хүчтэй тулхалт үүсэх, контактын сүлжээ элцөм халбалзах, дайвалзах, зорчигч болон хажуугаар өнгөрч байгаа хүн түгшүүртэй дуу, чимэг гаргах

-Гүйдэл хүлээн авагч сүлжээнээс мултарсан дохислол ажиглах

-Хөдөлгөөн саатуулсан саад гарах

Тайлбар: Хүний амь нас хохирч болзошгүй тохиолдол, хөдөлгөөний аюул учрах үед жолоч тrolleyбусыг яаралтай тормозоор зогсоох үүрэгтэй.

8.7.8. Үзэгдэх орчин муу байгаа нөхцөлд манан, цасан шуургатай үед жолоч тrolleyбусны бүх гэрлийг асааж богино хэмжээгээр дуут дохис огөн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хурдаар явна.

8.7.9. Жолооч халтирмалтай замд ажиглахдаа тормозны зам ихэсдэгийг анхаарах хэрэгтэй.

8.7.10. Хөдөлгөөний онцгой нөхцөлд жолоч замын байдал, үзэгдэх орчноос хамааран хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахуйц хамгийн тохиромжтой хөдөлгөөний горимыг сонгож ажиллах үүрэгтэй.

8.7.11. Кондуктортой үйлчилгээтэй тrolleyбусанд кондуктор, зорчигч бууж суунгуут хөдлөх дохис огох үүрэгтэй.

8.7.12. Бусад тээврийн хэрэгсэлийг тойрон өнгөрөх зогсоолд дөхөж очих үед жолоч тrolleyбусыг контактын сүлжээний утаснаас 4 м-ээс илүү холдуулж болгохгүй.

8.7.13. Нэг дор олон тrolleyбус цугларах тохиолдолд /хөдөлгөөн саатах, зам тээврийн осол гарах г.м./ жолоч гүйдэл хүлээн авагчийг буулгах үүрэгтэй, ба урд байгаа тrolleyбус 60 метрээс багагүй дөлдөж явсны дараа хөдөлгөөнийг эхэлнэ.

8.7.14. Тэмтэлтэй тrolleyбусыг цено болон засварын цэг рүү чирч явах маршрутад энэ үед авах аюулгүй ажиллагааны арга хэмжээ хөдөлгөөний журмыг тrolleyбусны комбинатын боловсруулсан заавраар тогтооно.

8.7.15. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эд анги нь эвдэрсэн тrolleyбусыг чирэгдүүрөөр цено руу члуулахыг хориглоно.

8.7.16. Жолооч ээлжинд ажиглах хурдацаандаа гүйдэл хүлээн авагч, тормозны систем, дүүрэн бадалгаа гэсэн дугуйг шалган

троллейбусанд үзлэг хийж, илйн системийн тундасыг байнга гаргаж байх үүрэгтэй.

Жолооч илэрсэн эвдрэл, гэмтэл бүрийг элсийн буудлын диспетчер, шугамын засварчдад мэдэгдэж троллейбусны засвар, техникийн үйлчилгээний дэвтэрт тэмдэглэл хийх үүрэгтэй. Шаардлагатай үед жолооч троллейбусны номер, маршрутын тэмдгийг арчиж цөвөрлөн, гишгүүрийн цаас мөс хэгийг арилгана. Үзлэг хийх хугацааг троллейбусны комбинатын тушаалаар тогтооно.

8.7.17. Жолооч троллейбусаас гарах шаардлага гарвал /элсийн зогсоол дээр эсвэл замд/ троллейбусыг гар тормозоор хөдөлгөөнгүй зогсоож, хүчний болон удирдлагын хэлхээг салгасны дараа хөдөлгүүрийн эргэлт солигчийн баримулыг завсрын байдалд болгож, түүнийг авч ялгах гянтаагаа өмсөж бүхээгний хаалгаа хаагаад анхааралтай гэрнэ.

Налуу газар троллейбусны дугуйнд өмнөрөхөөс хамгаалах ивүүр тавина.

8.7.18. Троллейбус удаан хугацаагаар зогсох үед /гэмтэл гарч/ жолооч замын хөдөлгөөний дүрмийн дагуу хаалт тавина.

8.7.19. Зам тээврийн осол гарах үед жолооч троллейбусаа орхихыг хатуу хориглоно.

8.7.20. Шугамд гарсан осол, хөдөлгөөний саатал бүрийн тухай жолооч өөрийн биеэр төвийн диспетчэрт телефонсоор эсвэл хөдөлгөөний албаны шугамын ажлычин болон зөрж яваа троллейбусны жолоочоор дамжуулан мэдэгдэх үүрэгтэй.

8.7.21. Албан үүргийн зааварт зааснаас өөр хүнд жолооч троллейбусны жолоо шилжүүлэхийг хориглоно. Жолос шилжүүлсэн тухай замын хуудсанд тэмдэглэнэ.

8.7.22. Золжийн жолоочдоо троллейбусаа хүлээлгэж өгөхдөө жолооч дараах зүйлийг мэдэгдэх ёстой.

Үүнд:

-Троллейбусны техникийн байдал, золжийн үед гарсан эвдрэл, гэмтлийн тухай

Троллейбус жолоодох горим, холбогдох хүмүүсээс авсан үүрэг даалгаврын тухай:

-Замын байдал, контактын сүлжээний тухай

-Чанга эргэгч хэрэгсэл, касс, компостерын ажиллагааны тухай

8.7.23. Ээлжийн жолоочоос троллейбусыг хүлээн авахдаа жолооч троллейбусны бүрэн бүтэн байдлыг албан үүргийн зааварт заасны дагуу шалгана. Жолооч троллейбусыг хүлээн авч засвар техникийн үйлчилгээний дэвтэр, замын хуудсанд гарын үсгээ зурна.

8.7.24. Жолооч албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа улсын автотехникийн хэргийг шалган байцаах газраас өгсөн троллейбус жолоодох эрхийг үнэмлэх жолоочийн дэвтэр, замын хуудас, хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн техник ашиглалтын ба хэрэглэгчийн цахилгаан тоногмолын ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн мэдлэг шалгасан үнэмлэхийг биедээ авч явах ёстой.

8.8. Хөдөлгөөний хурд.

8.8.1. Троллейбусны хөдөлгөөний хамгийн дээд хурдыг замын хөдөлгөөний дүрэм, энэ дүрмийн заалтуудыг үндэслэн троллейбусны комбинатаас тогтооно.

8.8.2. Жолооч, зам, цаг агаарын нөхцөл, хөдөлгөөний эрчим мөнзөрчигчдын тоо, бусад онцлог байдлыг тооцон, тогтоосон хурдыг хэтрүүлэхгүйгээр троллейбусыг жолоодно. Хэрвээ гэнэтийн аюул тохиолдвол жолооч хөдөлгөөний хурдыг багасгах эсвэл бүрэн зогсоох арга хэмжээ авах ёстой.

8.8.3. Досрхи нөхцөлүүдэд троллейбусны хурдыг хязгаарлана.

Үүнд:

-40-50 хувийн налуу газарт 40 км/цаг

-50-70 хувийн уруу газарт 35 км/цаг

-70-90 хувийн уруу газарт 30 км/цаг

-Төмөр замын гарам, дээр, троллейбусыг чирэх, шил арчигч ажиллахгүй /цаг бөрөөтэй үед засварын газар хүртэл явахад./ зам дээр ажил хийгдэж байгаа газрын хажуугаар 20 км/цаг

-Цэргийн цуваа, жагсаал, зогсож зүй автомашин, эвдэрсэн троллейбусыг гүйцэж түрүүлэх, замын үзэгдэх орчин муу, 70 метрээс бага радиустайгаар эргэх үед 15 км/цаг

-Контактын сүлжээний сумыг өнгөрөхөд 10 км/цаг

-Явган зорчигч их цугларсан газар, ухрах хөдөлгөөн үйлдэх, депогийн орчим, үзэгдэх орчин муу /эргэн манан, цасан шуурга/ троллейбусны гүйдэл хүлээж явагчийн тулгуур нь контактын сүлжээний тэнхлэгээс зөвшөөрөгдсөн хэмжээнээс их хазайлттай, усаар дүүрсэн замын хэсэгт 5 км/цаг

Тайлбар: 1. Замын гадаргуу нь 150мм-ээс дээш гүн нойтон цас, усаар хучигдсан байвал троллейбусны хөдөлгөөнийг хориглоно.

2.Хазар, намар, өвлийн хальтиргаатай нөхцөлд хөдөлгөөний тогтоосон курдыг 2 дахин багасгана.

8.8.4. Хөдөлгөөний хүнд нөхцөлтэй, налуу, гүүрэн гарцтай ба хөдөлгөөний өндөгт горж цаарцагатай хэсэгт троллейбусны хөдөлгөөний хурдыг хязгаарласан тэмдэг, заалтыг сайн үзэгдэх газар байнга байрлуулах ёстой.

8.9.Дохимол:

8.9.1.Дохимол нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөнийг нарийн зохицуулах, маневрын ажилд зориулагдсан байна.Дохимол нь үг дүүгүй биелүүлэх тушаал мөн.

8.9.2.Дохимол буруу эсвэл ойлгомжгүй байвал хөдлөх бүрэлдэхүүнийг заавал зогсооно.

8.9.3.Троллейбусны хөдөлгөөнтэй холбоотой дохиоллыг троллейбусны комбинатаас тогтоосон троллейбусны замын, хөдөлгөөн зохицуулах гэж 3 ангилна.

8.9.4.Троллейбусны дохиоллол:

-Урд, хоёр талын болон хажуугийн чиглэл заагч;

-Аваарын гэрэл

-Эргэлт, зогсолтын гэрэл

-Жолооч, кондуктор, зорчигчоос өгөх дуут гэх мэт дохиолол хамаарагдана.

8.9.5.Троллейбусны комбинатаас тогтоосон замын дохиолол :

-Гэрлэн дохиолол

-Хөдөлгөөний хурд хязгаарлах тэмдэг

-Троллейбусны жолоодлогын гөршмйн тэмдэг

-Заагч тэмдэг /зогсоолын цэг, эцсийн болон эхний зүгсөөл
г.м/

-Ажил хийж байгаа эсвэл саалтай газрыг хязгаарласан зөөв-
рийн гэрэл тэмдэг

-"Өгсүүр", "Уруу", "Огцом эргэлт" гэсэн бичээс

-Троллейбусны чиглэлийн бөрчлөлтийг заасан тэмдэгүүд
хамаарагдана.

8.9.6. Замын хөдөлгөөнийг зохицуулах дохиололд БНМАУ-
ын Нийгмийг аюулаас хамгаалах яамны Автотехникийн хэргийг
шалган байцаах газраас тавьсан тэрхэн дохиол

-Зохицуулагчийн дохио

-Замын тэмдэг заалт

8.9.7. Илосч нарын өөр хоорондын болон кондуктор, лу-
гамын ажилтан, зорчигчидтой харьцах дохио /Хүснэгт -3/

Дохиог: 1.Гараар, тугаар, дөмлүүгээр /шөнө/

2.Гар, хонх, шүтэл

3.Дуут дохио

Хүснэгт 3

Дохионы заалтын утга	Дохио	Дохио өгсөн хүн	Хэнд, ямар тохиолдолд өгөх
Урагшлах хөдөлгөөн	нэг урт эсвэл нум хэлбэрийн хөдөлгөөн ийг толгой дээгүүрээ хийх	Жолооч кондуктор жолооч, шугамын ажилтан, кондуктор	сувгаас гарах үед засварын ажигчдад зорчигчдыг бууж, сууж дууссаны дараа жолоочид троллейбус урагшаа хөдлөх тохиолдолд
ухрах хөдөлгөөн	Хоёр урт эсвэл холийн ойролцоо нум хэлбэртэй хөдөлгөөн хийх	Жолооч, шугамын ажилтан кондуктор	Депо дотор ажиллаж байхдаа засварчдад троллейбусыг ухраах үед жолоочид
Сөөлөн хурцтай явах	Хоёр богино эсвэл дохио өгөгч баруун талдаа дээш доош удаан хөдөлгөөн хийх	Шугамын ажилтан	Ямар нэгэн шалтгаанаар түр хугацаагаар хөдөлгөөний хурдыг бууруулах бүх нөхцөлд жолоочид
Зогс	3 удаа богино эсвэл сөрийн урд талд тойрог хэлбэртэй хөдөлгөөн	шугамын ажилтан кондуктор	Троллейбусыг яаралтай зогсоох үед жолоочид
Троллейбуснаас болгосмжил	нэг богино эсвэл богино хэмжээний үлэмэлтэй дохионуул	Жолооч	Тээврийн хэрэгслэлийн жолооч нарт, явган зорчигчлод, зам засварын ажигчдад, үзэгдэх орчин муу үед мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэхийн тулд өгнө
Шаардлагаар зогсоох	үргэлжлэлтэй	Зорчигч	Троллейбусыг зогсоох шаардлагатай үед жолоочид

8.10. Троллейбус шугамаас буцаж депод ирэх:

8.10.1. Троллейбус нь депоруу шугамаас дараах тохиолдолд буцаж ирнэ. Үүнд:

-Хуваарийн дагуу ажил дууссаны дараа

-Төв /ахлах/ диспетчерийн вийцвэрээр

-Аваарт орсон, хсдэлтөөний аюулгүй байдал хангахгүй

8.10.2. Жолосч депогийн талбайруу орохын өмнө троллейбусыг зогсоож дотор нь гаднын хүн байгаа эсэхийг шалгах ёстой.

8.10.3. Жолосч троллейбусаа хүлээлгэн өгөхдөө бүх гэмтлийг засуулах тухай захиалга өгөх үүрэгтэй. Хэрвээ гэмтлийг арилгаагүй бол засвар техник үйлчилгээний бүртгэлд зохих тэмцэглэлийг хийнэ. Харин гэмтэл дахин гарсан бол давтан захиалгын дэвтэрт бичих ёстой.

8.11. Троллейбусаар зорчих дүрэм

8.11.1. Троллейбусаар зорчих дүрмийг БНМАУ-ын Тээврийн яам, Хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргаа батлана. Энэ дүрмээр зорчигчдыг троллейбусаар зорчих болон зорчигч, троллейбусны цугамын ажилчдын хоорондын харилцах журмыг тогтооно.

8.11.2. Троллейбусаар зорчих дүрмийг зорчигчийн зааланд харгалдах гэжар байрлуулна. Энэ дүрмийг зорчигчид заавал биелүүлэх үүрэгтэй.

ТРОЛЛЕЙБУСНЫ ТЕХНИК АШИЛАЛТЫН
ДҮРЭМД ХЭРЭГЛЭГДЭХ НЭР ТОМБЭС

Шулуутгагч агрегат:

Хувьсах гүйдлийг тогтмол болгон хувиргадаг трансформа-
тор, шулуутгагч, өндөр хүчдэлийн ба катодын таслуур, тэд-
гээрт хамаарагдах багаж, а==арагуудаас бүрдсэн хэрэгсэл

Хөдлөх бүрэлдэхүүний овор хэмжээ:

Хажуу тийш хазайгаагүй байх үеийн захын хэмжээ зөвшөө-
рөгдсөн элэгдэл бүхий троллейбусыг хоосон ба ачаалалтай
байдлаар тэгш шулуун зам дээр байрлуулахад үүсэх замын тэнх-
лэгтэй хөндлөн перпендикуляр байх хамгийн их хүрээлэх га-
даргуу

Бүтцийн ойлгох овор:

Замын тэнхлэгтэй хөндлөн перпендикуляр байх хөдлөх бү-
рэлдэхүүнтэй шууд холбоотой хөдлөх бүрэлдэхүүний оворын
хэмжээ доторхи орон зайд байрлан троллейбусны хэсэгтэй
холбогдож түүний элементүүдтэй нь харьцах ба харьцахгүй
тоног төхөөрөмжөөс бусад тоног төхөөрөмж, материал салбэг
хэрэгсэл орохгүй хүрээлэх гадаргуу

Дело:

Хөдлөх бүрэлдэхүүний хадгалалт, засвар техникийн үйл
чилгээ хийх их бүрэн барилга байгууламж

Интервал:

Дарааллах явца хоёр троллейбусны хоорондох хугацаа
/минутаар/

Тэжээгч шугам:

Тогтмол гүйдлийн цахилгаан татах дэд станцын "шин"-
ээс контактын сүлжээний утсанд цахилгаан хүч дамжуулах
нэмэх хасах потенциалтай хүчний автомат багажнуудаас бүрц-
сэн кабелийн ба агаарын шугам

Замын хуудас:

Троллейбусны делогоос гарахыг зөвшөөрсөн, шугамд ажиллаж байгаа хөдлөх бүрэлдэхүүн, жолоочийн ажлыг тосгох зориулалттай баримт бичиг

Зогсоол хоорондын зай:

Зоргалдээ хоёр зогсоолоор хязгаарлагдсан троллейбусны шугамын хэсэг

Гарам:

Төмөр зам, троллейбусны шугамын нэг түвшин дээрх огтлолцоо

Бүтэцтэй төлөвлөгөө:

Объектын зохион байгуулалт, тохижилт, барилга байгууламжийн байршил, Тээврийн нам, харилцаа, инженерийн байгууламж аж ахуй, ахуйн үйлчилгээний асуудлын их бүрэн шийдлийг тусгасан зураг төсөл

Хүлээх талбай:

Троллейбус хүлээх, зорчигч буух суух газар

Цахилгаан татах дэд станц:

Хөдлөх бүрэлдэхүүнийг тэжээлээр хангах зорилгоор хүчдэл өөрчлөх, гүйдлийг шулуутгах, цахилгааны дэд станц

Автомат цахилгаан татах дэд станц:

Агрегат, оролт, өөрийн хэрэгцээний тоног төхөөрөмж нь нөөцийн автомат залгалттай, шугаман таслуурууд нь автомат давсан залгалттай дэд станц. Дэд станцад дуут ба гэрлэн дохиолол байна

Төлөмеханикийн удирдлагатай цахилгаан татах дэд станц:

Агрегат, оролтуудыг диспетчерийн байрнаас алсаас удирддаг автомат цахилгаан татах дэд станц

Цуваа /троллейбусны цуваа/:

Жолооч болон бригадаараа шугамын үйлчилгээнд ажиллаж байгаа нэг троллейбус буюу хэсэг троллейбус

Олон нэгжийн системийн нэгдсэн жолоодлоготой цуваа:

Нэг байрнаас жолоодогддог хоёр түүнээс илүү троллейбусаас бүрдсэн цуваа

Районы диспетчерийн байр:

Цахилгаан татах дэд станц, шугамын тоног төхөөрөмж, телемеханикийн сувганд гарсан гэмтлийг арилгах зориулалттай зарим төрлийн засвар, техникийн үйлчилгээ хийх боломжтой райончилсон цахилгаан татах дэд станц шугамын тоног төхөөрөмжийн телемеханикийн удирдлагын байр

Тормозны зам:

Троллейбус тормозлож эхлээд бүрэн зогсох хүртэл явсан зай

Цахилгаан татах дэд станцын тэжээх хүрээ:

Тухайн дэд станцаас цахилгаан эрчим хүчээр тэжээгдэж байгаа контактын сүлжээний хэсгүүд

Хөдөлгөөний хуваарь:

Троллейбусны шугамд ажиллах горимыг тогтоож өгсөн баримт бичиг

Хагас рейс:

Маршрутын нэг эцсийн зогсоолоос нөгөө эцсийн зогсоолд хүрэх троллейбусны гүйлт

"0" рейс:

Деногоос маршрутын эцсийн зогсоол хүртэл, эсвэл эцсийн зогсоолоос дено хүртлэх троллейбусны гүйлт

Бүтэн рейс:

Маршрутын нэг эцсийн зогсоолоос нөгөөд хүрээд буцаж ирэх троллейбусны гүйлт

Богино рейс :

Эцсийн зогсоолоос маршрутын эль нэг дундын зогсоол хүртлэх троллейбусны гүйлт

Контактын сүлжээний хэсэгтэй:

Тэгээх дугаар дамжигдан цахилгаан татах дэд станцын "Шин" -д салангил холбогдож бие биеэсээ тусгаарлагдсан контактын сүлжээний хувастдмал хэсгүүд

Контактын сүлжээ :

Хөдлөх бүрэлдэхүүний гүйдэл сүлжээн авагчид хүчдэл өгөхөд зориулагдсан гүйдэл дамжуулагч, тусгаарлагч сагаж, эд анги, тогтоох тоноглолуудны бүрдэл

Дохиромлол:

Томьёолсон үзэгдэх тэмцэг эсвэл тодорхой заавар захирамж өгөх дуу

Цахилгаан хангамжийн систем:

Цахилгаан эрчим хүчийг хүлээн авах, хувиулах, хуваарилах, төхөөрөмжүүдийн нэгдэл

Төвлөрсөгүй цахилгаан хангамжийн систем:

Контактын сүлжээний хэсэг бүр нь мнрийн горимдоо зөргөлдөө орших хоёр цахилгаан татах дэд станцаас тус тусдаа тэжээгдсэн систем, цахилгаан татах дэд станцууд нь хэсэгчлэгч тусгаарлагчийн ойролцоо байрлах ба ардын горимдос зөвхөн сийр орших контактын сүлжээг тэжээгнэ. Цахилгаан татах дэд станцуудыг бие биеэсээ бүрэн орлохоор тооцсон байна.

Төвлөрсөн цахилгаан хангамжийн систем:

Их хүчин гадаргатай амь нэг цахилгаан татах дэд станц нь ойролцоо болон аслагдсан н контактын сүлжээний хэсгүүдийг тэжээгнэ.

Хөдлөх бүрэлдэхүүн:

Зорчигч тэвэрэх, агаани болон тусгай зориулалтын троллейбусууд /сургуулийн гэх мэт/

Троллейбус:

Газар дээрх зорчигч тэврийн хэрэгслийн төрөл. Хөдөлгөөний үед контактын сүлжээнээс эрчим хүч авч явдаг зогж

хөдлөх бүрэлдэхүүн

Хуваарилах эцсийн зогсоол:

Хөдлөх бүрэлдэхүүнд жижиг засвар хийх, хадгалах, троллейбус удаан хугацаагаар зогсоох, хүлээн авах, тойрч гарах зориулалтын салбарласан контактын сүлжээтэй мөн албаны болон жолооч нарын ариун цэвэр, ахуйн өрөө бүхий талбай

Техникийн эцсийн зогсоол:

Салбарласан контактын сүлжээтэй хөдөлгөөнд хяналт тавих хэрэгсэл болон цахилгаан цагаар тоноглогдсон зорчигчдын саравч бүхий буух суух талбайтай эцсийн цэг

Автомат сум:

Жолоочийн сонгосон амь нэг чиглэлд гүйдэл хүлээн авагчийг шилжүүлэх сум

Уулзах сум:

Троллейбусны хоёр шугамыг нэгтгэдэг хөдлөх эд ангигүй сум
Зориулалтаар тормозлох:

Хөдлөх бүрэлдэхүүнийг хурдыг заммаар бууруулах эсвэл урьдчилан тооцсон зогсоолд зогсоохоор тормозлох

Огцом тормозлох:

Хөдлөх бүрэлдэхүүнийг түргэн хугацаанд яаралтай зогсоохоор бүх төрлийн тормозыг зэрэг ажиглуулах

Налуу:

Хэвтээ шугамандаа налуутай замын тууш зүсэлтийн элемент Доод цэгээс дээд цэг хүртлэх хөдөлгөөний үе дэх налууг өгсүүр, эсрэг тохиолдлыг уруу гэж нэрлэнэ.

Өнхөрөхөөс хамгаалах ивүүр:

Троллейбусыг өөрөө өнхөрөхөөс хамгаалж дугуй дор тавих хэрэгсэл

Ажиллаж эхлэх үеийн хэмжээ:

Аппарат ажиллаж эхлэх тосон утга энэ тосон утгаар өг гаратыг тохируулна.

Хөдөлгөөний давтамж:

Нэгж хугацаанд нэг чиглэлд явах троллейбусны тоо /гол төлөв /1 цагт/

Троллейбусны их бүрдэлт:

Троллейбусны шугаманд ажиллахад суурь дүндлэлгүй тоногдол, багаж хэрэгсэл, салбар, материал, барилда зэргээр хийгдэх

" -

БАТАЛГАА

Надад гардуулж өгсөн "Троллейбусны техник ашиглалтын дүрэм"-ийг судлаж, шиний _____ ажил үүргийн зааварт хамаарах заалтуудыг гуйвартгүй биелүүлж ажиллахаа амлаж байна.

Ахлаас халагдах ба шаардлага гарсан үед энэ дүрмийг заавал буцааж өгнө.

Свог нэр _____
 Ажлын газар _____
 Албан тушаал _____
 Гарын үсэг _____

_____ он _____ сарын _____ ны өдөр

Троллейбусны техник ашиглалтын дүрмийг судалж, шалгалт өгсөн дүн

19 _____ оны _____ сарын _____ өдрийн

ШАЛГАЛТЫН КОМИСС

Хурлын багш



Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, БНМАУ-ын Тээврийн яамны 1987 оны 284/326 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт

ТРОЛЛЕЙБУСААР ЗОРЧИХ ДҮРЭМ

Энэ дүрмийн гол зорилго нь нийслэл Улаанбаатар хотын зорчигч тээврийн үйлчилгээг хөдөлгөөний аруулгүй байдлыг ханган, троллейбусны хурд, тогтоосон графикийг мөрдөн ажиллах нөхцөлийг бүрдүүлж, нийслэлийн хөдөлмөрчдийн үйлчилгээг хэвийн жигд явуулахад оршино.

I. Троллейбусны жолооч нарны үүрэг

I.1. Үйлчлэх чиглэл, цагийн график, куваарийг хатуу мөрдөж, зорчигчдод хөнгөн шуурхай, соёлч боловсон үйлчилж тэдэнд анхаарал халамж тавьж ажиллах.

I.2. Троллейбусны заалтны багтаажийг харгалзан зорчигчдын суух тоог хязгаарлаж байх.

I.3. Зогсоол, дараагийн зогсоол бүрийг зорчигчдод үнэн зөв зарлах, харин явах маршрут өөрчлөгдсөн тохиолдолд зогсоол бүр дээр энэ тухай тодорхой зарлаж байх.

I.4. Өндөр настан, бага насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдэд суудал тавьж өгөх талаар зорчигчдод хандаж шаардлага тавих.

I.5. Троллейбусны гадна, дотно цэвэрлэгээг өдөрт 3-аас доошгүй удаа тогтмол хийж өнгө үзэмжтэй троллейбусаар хөдөлмөрчдөд үйлчлэх.

I.6. Троллейбус эвдэрч гэмтсэн тохиолдолд дараагийн троллейбуснуудыг дохио өгч зогссон зорчигчдыг суулгах.

I.7. Троллейбусны техник ашиглалтын дүрэмд заагдсан тохиолдолд кабиндаа хүн суулгаж явах.

I.8. Сургуулийн өмнөх насны хүүхэдтэй зорчигч, өндөр настан, жирэмсэн эмэгтэйчүүд, тахир дутуу хүмүүсийг дунд хаалгаар, троллейбусны үйлчилгээний дэг журам захиулахаар албан үүргээ гүйцэтгэх яваа эрх бүхий хүмүүсийг урд хаалгаар суулгах.

I.9. Троллейбус бүрэн зогссонны дараа буудал дээр хүнээ буулгах.

2.Зорчигчдын үүрэг

2.1.Зорчигчид нь троллейбус бүрэн зогссон дараа дарааллын журмыг баримтлан зөвхөн хойд хаалгаар орно.Троллейбусны багтаамж хэтэрсэн тохиолдолд дараагийн троллейбусанд суух.

2.2.Зорчигчид нь троллейбусанд суухаас өмнө хяналтын болон байнгын билетийг урьдчилан худалдаж авсан байх.

2.3.Зорчигчид нь троллейбусанд суугаад дараагийн буудал хүрэхээс өмнө хяналтын билетийг комюстероор цоолсон байх.

Сарын байнгын билет болон үнэгүй зорчих эрхийн баримт бичгээ жолооч болон зорчигчдод дэмлэгэн харуулах.

2.4.Комюстероор цоолсон хяналтын билет нь нэг л удаа нэг л зүг рүү зорчиход хүчинтэй.

2.5.Зорчигчид бүх төрлийн билет мөн үнэгүй зорчих эрхийн баримт бичгээ жолооч, билет шалгагч болон бусад эрх бүхий хүмүүсийн анхны шаардлагаар шалгуулах.

2.6.90 х 60 х 20 см хүртэл хэмжээний тээш 150 см хүртэл урт зүйл /цанаас бусад/ тус бүрийг нэг хяналтын билет комюстероор цоолж төлөх.

2.7.Сарын байнгын билет, үнэгүй зорчих эрхтэй зорчигчид тээшний хөлсийг төлөх.

2.8.Зорчигчид хяналтын билетийг буух газраа хүртэл хадгалж, буусны дараа хогийн саванд хийх.

2.9.Зорчигчид троллейбусанд мартагдсан зүйлийг жолооч эсвэл эцсийн буудлын диспетчерт хүлээлтгэж өгөх.

2.10.Троллейбусаар зорчих дүрмийг зөрчсөн, зорчих хөлс төлөөгүй хүмүүст нийтээр шаардлага тавих.

2.11.Сандал, суудал, хаалга, цонхыг эвдэлгүй, хог хаяхгүй байх.

2.12.Эцсийн буудал дээр зорчигчид бүгд бууж троллейбусны заалыг бүрэн судласан байх.

2.13.Өндөр настан, жирэмсэн эмэгтэйчүүд, бага насны хүүхэдтэй зорчигчдод хүндэтгэн суудал тавьж өгөх.

3.

3. Зорчигчдын эрх

3.1. Сургуулийн өмнөх насны хүүхдийг хөлс төлөхгүй авч явах.

3.2. Саатаж зогсоон троллейбусны компостероор цоолсон хяналтын билетээр дараагийн троллейбусанд суухыг зөвшөөрнө.

4. Жолоочид хориглох зүйл

4.1. Троллейбусны галца, дотно өнгө үзэмж, ариун цэвэр шаардлага хангахгүй байх.

4.2. Тогтоосон хэмжээнээс илүү зорчигч тээвэрлэн троллейбусны багтаамж хэтрүүлэх.

4.3. Тогтоосон буудлаас өөр газар зогсож хаалга онгойлгон зорчигчийг буулгах, суулгах.

4.4. Замын хөдөлгөөний дүрэм зорчих, тогтоосон хурд хэтрүүлэх.

4.5. Кабинд тамхи татах, зөвшөөрөлгүй хүн суулгах.

4.6. Зорчигчийн зааланд зориулалтын бус элдэв зүйл тавих.

4.7. Хаалга бүрэн хаахгүй явах.

4.8. Зорчигчидтой зүй бусаар харьцах.

5. Зорчигчдод хориглох зүйл

5.1. Троллейбус дотор ууж согтууран хэвийн бус, бохир хувцастай явах, тамхи татах, хэрүүл маргаан гаргах, хог цаас халх, самар цөмөх, мал, нохой, муур зэрэг тэжээвэр амьтан, галт эвсэг, хурц үзүүр, иртэй эгил, тэсрэх бодис, бусдын хувцсыг бохирдуулах эд юмс, 90 х 60 х 20 см-ээс дээш, 150 см-ээс урт овор ихтэй ачаа тээш авч явах.

5.2. Цонхоор гар гаргах, цухуйх, суудал дээр хүүхэд зогсоох, ачаа тээш тавих.

5.3. Троллейбусны хаалганы гишгүүр болон зориулалтын бусад эд анги дээр зогсох, суух.

5.4. Троллейбусны багтаамж хэтэрсэн тохиолдолд хаалганаас зүүгдэх, хаалга нээж, хаахад саад учруулах.

5.5. Гэнэтийн асуулаас урьдчилан сэргийлэх шаардлагаас бусад тохиолдолд тормоз татах, хаалга нээх дохиог ажиллуулах.

4.

5.6. Троллейбусны урдуур тойрч явган хүний гарцгүй газраар зам хөндлөн гарах.

5.7. Троллейбусны тоног төхөөрөмжид хүрэх, оролдох, гүйдэл хүлээн авагчийн штанг бэхэлгээний оосроос татах, чангаах.

5.8. Контактын сүлжээний байгууламжид хүрэх, тасарсан цахилгааны утас, тросс унжсан газарт 20 м-ээс дотогш ойртох.

5.9. Жолоочтой ярих, түүний анхаарлыг сарниулах.

6. Зорчигчдын хүлээх хариуцлага

6.1. Зорчих хөлс төлөөгүй зорчигчдод -насанд хүрэгчдэд 5 төгрөг /торгуулийн хуудсаар/, сургуулийн насны хүүхдэд 1 төгрөг 50 /хяналтын 50 мөнгөний хоёр билет/-ний торгуулийг хяналт шалгалтын эрх бүхий хүмүүс /тээврийн улсын байцаагч, билет шалгагч, цагдан сэргийлэх байгууллагын ажилтан гэх мэт/ тавина.

6.2. Доорх тохиолдолд зорчих хөлс төлөөгүйд тусно. Үүнд:

а/троллейбусанд суугаад дараагийн буудал хүрэхэд хяналтын билетийг компостероор цоолоогүй, мөн шалгах үед түүнийг үзүүлэхгүй байх.

б/хугацаа дууссан сарын байнгын билетээр зорчих.

в/тухайн троллейбусанд тавигдсан компостерын нүхний тоотой хэрэглэсэн хяналтын билетийг цоолсон нүхний тоо тохирохгүй байх.

г/өөр хүний бичиг баримтаар явах, зорчих.

д/ачаа тээшний хөлс төлөөгүй байх.

6.3. Зорчин явалт, ачаа тээш авч явсны хөлс төлөөгүй торгуулсан зорчигчийг зорчин явалтын болон ачаа тээшний хөлс төлөх үүргээс чөлсөлөхгүй.

6.4. Троллейбус, түүний тоног төхөөрөмжийг эвдэх гэмтээсэн буруутай этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

үргэлжлэл

270



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА, ТЭЭВРИЙН
ЯАМНЫ 1987 ОНЫ 291/326 ТООТ ТОГ-
ТООЛЫН 3 ДУГААР ХАВСРАЛТ

Троллейбусаар зорчих билетийг борлуулах,
худалдах тооцох журам

Нэг. Ерөнхий зүйл

73.7.2 1988

321/326

1. Зорчигч тээврийн үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, ашиглалтын зардлыг багасгах зорилгоор троллейбусны үйлчилгээнд кондукторгүй үйлчилгээг нэвтрүүлнэ.

2. Троллейбусаар зорчигчдыг билетээр тасралтгүй хангах, билет борлуулсан байгууллага, хүмүүстэй тооцоо хийхэд энэхүү журмыг мөрдлөг болгоно.

3. Троллейбусаар нэг удаа зорчих хяналтын болон автобус, троллейбусаар зорчих сарын байнгын нэгдсэн билет /цаашид билет гэж нэрлэнэ/-ийг худалдаа нийтийн хоол, холбооны цэг салбарууд болон троллейбусны комбинатаас байгуулсан цэгүүдэд зарж борлуулна.

4. Троллейбусны комбинат нь билет борлуулах, тооцоо хийх тухай аж ахуйн гэрээг билет борлуулах цэг салбаруудыг удирдаж байгаа биеэ даасан аж ахуйн тооцоотой байгууллагатай хийнэ.

5. Билетийн орлого, зарлагын тооцоог БНМАУ-ын Сангийн Яам, Статистикийн төв газраас баталсан нэг хэвийн маягтаар хийнэ.

6. Билетийг БНМАУ-ын Сангийн Яамны сайдын 1967 оны 95 дугаар тушаалаар батлагдсан үнэт цаас хэвлүүлэх, бүртгэх, хадгалах журмын дагуу маш нарийн тооцож хадгална.

Хоёр. Хяналтын ба сарын нэгдсэн билетийн борлуулалт

1. Билетийг урьдчилан зарж зорчигчдын гарт хүрэх нь кондукторгүй үйлчилгээний үед зорчигчийн хөлс төлөлтийн асуудалтай нягт холбоотойгоор авч үзэж тогтоосон цэгүүдэд тасралтгүй бэлэн байлгах асуудлыг захиалагч, борлуулагч байгууллагууд шууд хариуцана.

2. Билетийг борлуулах, тооцоо хийх тухай гэрээг траллейбусны комбинат билет борлуулах аж ахуйн тооцотой байгууллага нэг бүртэй байгуулж, арбитрийн байгууллагаар батлуулна.

3. Билетийг борлуулах худалдагч нарыг хоёр байгууллагын цэргийн тушаалаар томилон ажиллуулж, тэдэнд борлуулалтын орлогоос 0,5 хүртэл хувьар тэдний ажлын харууллага сахилга бат, гэрээгээр авсан үүргийн биелэлтийг харгалзан шимтгэлийн орлогоос урамшуулал олгоно.

4. Гэрээт үүргээ сайн биелүүлж ажилласан худалдагч нарыг хагас, бүтэн жилээр шалгаруулан шагнал урамшуулал олгоно.

5. Билетийг худалдаа, нийтийн хоол, холбооны цэг салбарууд өөрсдийн ажиллах цагийн хувиар, Траллейбусны комбинатаас байгуулсан цэгүүдэд өдөр бүр 620 цагаас 2300 цаг хүртэл зарж борлуулна.

6. Нэг удаа зорчих хяналтын билетийг сарын бүх өдрүүдэд тогтоосон цэгүүдэд худалдах бөгөөд харин автобус, траллейбусаар зорчих сарын байнгын нэгдсэн билетийг сар бүрийн 25-наас дараа сарын 3-ий өдөр хүртэл мөн цэгүүдэд худалдана.

Турав. Траллейбусны комбинатын гүйцэтгэх үүрэг.

1. Билетийг хэвлүүлж, хүчин төгөлдөр болгож гэрээг борлуулагч байгууллагаас томилогдсон комисст сар бүр актаар хүлээлгэн өгнө.

2. Билет борлуулах ажлыг хөдөлмөрчдөд аль болохоор ойр дот байлгахын тулд Буянт-Ухаагийн нисэх онгоцны буудал, авто ба төмөр замын вакзал, авто тээврийн шалган бүртгэх Баянзүрх, Нармаг, 22-ын товчоо, хотын төвд байгаа автобусны болон ахуйн тээврийн диспетчерийг зарим цэгүүдэд билет борлуулах өөрийн цэгтэй байх ба билет шалгагч, траллейбусны жолооч нар зорчигч тээвэрлэлтийн явцад өөрсдөө билет борлуулах зэргээр зорчигчдыг билетгүй зорчих бололцоо гаргахгүйгээр зохион байгуулна.

Дээрхи цэгүүдийн диспетчер ба өөрсдийн цэгүүдийн билет худалдагч нар, буянт шалгагч, траллейбусны жолооч, нараас билет борлуулсны орлогыг өөрсдийн хүчээр өдөр бүр хураан авч банкинд тушааж байна.

3//

3. Автобус, троллейбусаар зорчих сарын байнгын нэгдсэн билетийн борлогдоогүй үлдэгдлийг борлуулагч байгууллагаас сар бүрийн 3-4-ны дотор хураан авч, акт тогтоон устгал хийж, тооцог мөн хугацаанд тогтмол хийж байна.

4. Долос хоног бүр билет худалддаг бүх цэг салбаруудад байгаа билетийн үлдэгдлийг борлуулагч байгууллагатай хамтран банкинд тушаасан бэлэн мөнгөний квитанцтай тулган шалгаж байна.

5. Сар бүрийн 13,28-нд гэрээ байгуулсан албан газар байгууллагаас билет борлуулалтын шуурхай мэдээг авч байна.

6. Билет борлуулсны орлогоос 3,0 хувиар бодож борлуулагч байгууллагад сар бүр шимтгэл төлж байна.

Дөрөв. Борлуулагч байгууллагын үүрэг.

1. Троллейбусны комбинатаас билетийг тусгай комисс томилон актаар хүлээж авах бөгөөд өөрсдийн цэг салбарын билет худалдагч нарт мөн тусгай актаар хүлээлгэн өгч байна.

2. Билет борлуулах худалдагч нарны хэвийн ажиллах нөхцлийг бүрэн хангаж билетийн орлогыг өдөр бүр банкинд тушаалгаж ер толбогүй ажиллахад нь байнга хяналт тавьж байна. Билет худалдагч нар борлуулсан билетийн орлогын мөнгөнөөс ямуу билетээс дутагдуулбал тэдэнд хууль тогтоомжинд заасан хариуцлага хүлээлгэн, хохирлыг тухайн сард нь багтаан толгоож троллейбусны комбинатад шилжүүлж байна.

3. Ээлж хооронд билет худалдагч нар билет ба билет борлуулсны орлогын мөнгөйг хүлээлэхгүй бөгөөд тус бүртээ тооцоо хийж байна. Ийм учраас ээлж бүр тусад нь билет тавьж олгоно.

4. Билетийг хүндрүүлэгчтэй мөнгөний авдарт хангалах ба талон худалдан борлуулсны орлогыг өдөрт нь банкны тунханд хийж тусгай батлагдсан праёкийн даруу банкны мөнгө хураагчид тушаалгаж байна.

5. Сар бүрийн 13,28-нд троллейбусны комбинатад билет борлуулалтын шуурхай мэдээг өгч тооцоо хийж байна.

4//

6. Долоо хоног бүрийн эцэст билетийн үлдэгдлийг биечлэн тоолж дүн мэдээг Троллейбусны комбинатад өгч байна.

Тав. Тооцоо хийх журам.

1. Нэг удаа зорчих хяналтын билетийн тооцоог сар бүрийн 13,28-нд тогтмол хийж байх бөгөөд автобус, троллейбусаар зорчих сарын байнгын нэгдсэн билетийн тооцоог сар бүрийн 3-4-ны хооронд хийж гэрээг дүгнэж байна.

2. Долоо хоног бүрийн эцэст үлдэгдэл билетийн тооцоо хийсний дараа дараагийн долоо хоногийн билетийг тавьж олгох бөгөөд харин урьд долоо хоногийн билетийн орлогын мөнгийг банкинд бүрэн тушаагаагүй байвал тушаагаагүй мөнгөний дүнгээс хугацаа хэтэрсэн хоног дутам 1,0 хувиар бодож билет борлуулагч нар т торгууль ноогдуулж байна.

3. Билет худалдагч нар ажлаас халагдах ямуу ээлжийн ба жирэмсний амралт авах үед хоёр газраас томилогдсон комисс тооллого хийж тооцоо бодсон акт үйлдэж, тооцоог бүрэн дуусгаж үлдэгдэл билетийг тушаалгана. Тооцоог бодож дуусаагүй үед борлуулагч байгууллага Троллейбусны комбинатад мэдэгдэлгүй билет худалдагч нарыг ажлаас халах буюу түр чөлөөлбөл түүнээс гарах хохирол төлбөрийг борлуулагч байгууллага бүрэн хүлээнэ.

Мөн урьд нь билет борлуулсны орлого ба билетээс дутагдуулаад түүнийгээ бүрэн төлж тооцоо дуусаагүй хүнийг ажлаас халж болохгүй. Хэрэв төлбөрөө төлж дуусаагүй байхад халсан байвал уг төлбөрийг борлуулагч байгууллага бүрэн хариуцна.

4. Троллейбусаар зорчигчдын билетийг борлуулах, тооцоо хийх үйл ажиллагаа нь захиалагч, борлуулагч байгууллагууцны хооронд хийгдсэн аж ахуйн гэрээгээр зохицуулагдаж байна.



Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх
Захираа, Тээврийн яамны 1987 оны
3 дугаар 328 тоот тогтоолын 4 дүгээр
хавсралт
13.12.1988 21/384

ХАНЫН МАТЕРИАЛЫН КОМБИНАТ-ТӨМӨР ЗАМЫН
ВОКЗАЛЫН ЧИГЛЭЛИЙН ЯВАХ МАРШРУТ № I

№	Буудлын нэр	№	Буудлын нэр
1.	Ханын материалын комбинат /эцсийн буудал/	19.	Төмөр замын вокзал /эцсийн буудал/
2.	ХҮБ-ны 28 дугаар дэлгүүр	20.	Зорчигч үйлчилгээний төв
3.	Авто сургууль	21.	МУЭ-ийн Соёлын төв ордон
4.	Троллейбусны комбинат	22.	Гагарины гудамж
5.	Үйлдвэрчний эвлэлийн гудамж	23.	Ахуй үйлчилгээний ордон
6.	Сүлжмэлийн үйлдвэр	24.	"Москва" ресторан
7.	32 дугаар байр	25.	Кинотеатр
8.	20 дугаар байр	26.	13-р сургууль
9.	ХҮБ-ны 88 дугаар дэлгүүр	27.	Гэмтлийн эмнэлэг
10.	Үйлчилгээний төв	28.	Хотын клиникийн төв эмнэлэг
11.	Хотын клиникийн төв эмнэлэг	29.	Үйлчилгээний төв
12.	Гэмтлийн эмнэлэг	30.	ХҮБ-ны 88-р дэлгүүр
13.	13 дугаар сургууль	31.	20 дугаар байр
14.	Кинотеатр	32.	32 дугаар байр
15.	"Москва" ресторан	33.	Сүлжмэлийн үйлдвэр
16.	Ахуй үйлчилгээний ордон	34.	Үйлдвэрчний эвлэлийн гудамж
17.	Гагарины гудамж	35.	Троллейбусны комбинат
18.	Төмөр замчдын соёлын ордон	36.	Автосургууль
		37.	ХҮБ-ны 28 дугаар дэлгүүр

ТАЙЛБАР: 1. Троллейбусаар үйлчлэх хугацаа:
эхлэх 6³⁰ /эцсийн зогсоолоос/
дуусах 23³⁰ /эцсийн зогсоолд/

2. Ханын материалын комбинат-Төмөр замын вокзалын чиглэлийн троллейбусны хөдөлгөөний интервал
6³⁰ - 9⁰⁰ цагт 3 - 4 мин
9⁰⁰ - 16⁰⁰ цагт 6-8 мин
16⁰⁰ - 20⁰⁰ цагт 3-4 мин
20⁰⁰ - 22⁰⁰ цагт 8-10 мин
22⁰⁰ - цагаас хойш 12-15 мин



Улаанбаатар хотын АДЖ-ын гүйцэтгэх
 гүйцэтгэлгээ, Тээврийн яамны 1987 оны
 захирал 26 тоот тогтоолын 4 дүгээр
 хавсралт

МАХ КОНСЕРВИЙН КОМБИНАТ-ТӨМӨР ЗАМЫН
 ВОКЗАЛЫН ЧИГЛЭЛИЙН ЯВАХ МАРШРУТ № 2

№	Буудлын нэр	№	Буудлын нэр
1.	Мах консервийн комбинат /эцсийн буудал/	16.	Зорчигч үйлчилгээний төв
2.	Сүлжмэлийн үйлдвэр	17.	МУЭ-ийн Соёлын төв ордон
3.	32 дугаар байр	18.	Гагарины гудамж
4.	20 дугаар байр	19.	Ахуй үйлчилгээний ордон
5.	ХҮБ-ын 88 дугаар дэлгүүр	20.	"Москва" ресторан
6.	Үйлчилгээ ий төв	21.	Кинотеатр
7.	Хотын клиникийн төв эмнэлэг	22.	13-р сургууль
8.	Гэмтлийн эмнэлэг	23.	Гэмтлийн эмнэлэг
9.	13 дугаар сургууль	24.	Хотын клиникийн төв эмнэлэг
10.	Кинотеатр	25.	Үйлчилгээний төв
11.	"Москва" ресторан	26.	ХҮБ-ны 88-р дэлгүүр
12.	Ахуй үйлчилгээний ордон	27.	20 дугаар байр
13.	Гагарины гудамж	28.	32 дугаар байр
14.	Төмөр замчдын соёлын ордон	29.	Сүлжмэлийн үйлдвэр
15.	Төмөр замын вокзал /эцсийн буудал/	30.	Геологийн төв лаборатори
		31.	Мах консервийн комбинат

ТАЙЛБАР: 1. Троллейбусаар үйлчлэх хугацаа:

эхлэх 6³⁰ /эцсийн зогсоолоос/

дуусах 23³⁰ /эцсийн зогсоолд/

2. Мах консервийн комбинат - Төмөр замын вокзалын

чиглэлийн троллейбусны хөдөлгөөний интервал

6 ³⁰	-	9 ⁰⁰	цагт	3-4 мин
9 ⁰⁰	-	16 ⁰⁰	цагт	6-8 мин
16 ⁰⁰	-	20 ⁰⁰	цагт	3-4 мин
20 ⁰⁰	-	22 ⁰⁰	цагт	8-10 мин
22 ⁰⁰	-	цагаас хойш		12-15 мин